Бремен (Bremen)	Док. Хенниг Шерф /ГСДН/ (Präs.d.Senats B-Dr. Hennig Scherf) Хартмут Першай /ХАХ/ (Stellv. B-Hartmut Perschau)
Бремерхафен (Bremerhaven)	Иорг Шульц /ГСДН/ (OB- Jörg Schulz)
Хемнитц (Chemnitz)	Док. Петер Зайферт /ГСДН/ (OB Dr. Peter Seifert)
Коттбус (Cottbus)	Валдемар Клайншмидт /ХАХ/ (OB- Waldemar Kleinschmidt)
Дармштадт (Darmstadt)	Петер Бенц /ГСДН/ (OB- Peter Benz)
Дортмунд (Dortmund)	Док. Герхард Лангемейер /ГСДН/ (OB- Dr. Gerhard Langemeyer)
Дрезден (Dresden)	Док. Ингольф Россберг /ЧАН/ (OB-Dr. Ingolf Rossberg)
Дуисбург (Duisburg)	Вэрбел Цийлинг /ГСДН/ (OB- Bärbel Zielsing)
Дюсельдорф (Düsseldorf)	Иоахим Эрвин /ХАХ/ (OB- Joachim Erwin)
Эрфурт (Erfurt)	Манфред Руге /ХАХ/ (OB- Manfred Ruge)

Эрланген (Erlangen)	Док. Зийгрийф Баллайс /ХНХ/ (OB- Dr. Siegfried Balleis)
Эссон (Essen)	Док. Вольфганг Райнигер /ХАХ/ (OB-Dr. Wolfgang Reiniger)
Франкфурт/Майн (Frankfurt/Main)	Петра Рот /ХАХ/ (OB- Petra Roth)
Фрайбург (Freiburg)	Док. Рольф Бээме /ГСДН/ (OB- Dr. Rolf Böhme)
Фурт (Furth)	Вильхелм Веннинг /ХНХ/ (OB- Wilhelm Wenning)
Гользинкирхен (Gölsenkirchen)	Оливер Виттке /ХАХ/ (OB-Oliver Wittke)
Гера (Gera)	Ральф Раух (OB- Ralf Rauch)
Готтинген (Göttingen)	Юрген Даниеловский /ХАХ/ (OB- Jürgen Danielowski)
Хаген (Hagen)	Вильфрид Хорн /ХАХ/ (OB- Wilfried Horn)
Халле/Заале (Halle/Saale)	Ингрид Хойслер /ГСДН/ (OB- Ingrid Häussler)
Хамбург (Hamburg)	Ортвин Рунде /ГСДН/ (Präs.d. Senats: 1. B- Ortwin Runde) Криста Загер /Ногоонтны нам/ (2. B- Krista Sager, Grüne/GAL)
Хамм (Hamm)	Томас Хунштегер -Петерманн /ХАХ/ (OB- Thomas Hunsteger-Petermann)
Ханновер (Hannover)	Херберт Шмалштиг /ГСДН/ (OB- Dr.h.c. Herbert Schmalstieg)
Хайделберг (Heidelberg)	Беате Вебер /ГСДН/ (OB- Beate Weber)
Хайлбронн (Heilbronn)	Хельмут Химмельзбах (OB- Helmut Himmelsbach)
Херне (Herne)	Вольфганг Бекер /ГСДН/ (OB- Wolfgang Becker)
Хильдесхайм (Hildesheim)	Курт Махенз /ХАХ/ (OB- Kurt Machens)
Ингольштадт (Ingolstadt)	Петер Шнель /ХНХ/ (OB- Peter Schnell)
Кайзерслаутерн (Kaiserslautern)	Бернхард Дойбиг /ХАХ/ (OB- Bernhard Deubig)
Карлсруэ (Karlsruhe)	Хайнц Фенрих /ХАХ/ (OB- Heinz Fenrich)

Кассел (Kassel)	Георг Левандовский /XAX/ (OB- Georg Lewandowski)
Кийл (Kiel)	Норберт Ганзел /ГСДН/ (OB- Norbert Gansel)
Кобленц (Koblenz)	Док. Эберхард Шульте-Виссерманн /ГСДН/ (OB- Dr. Eberhard Schulte-Wissermann)
Көln (Köln)	Фритц Шрамма /XAX/ (OB- Fritz Schramma)
Крефельд (Krefeld)	Дийтер Пүтцхофен /XAX/ (OB- Dieter Pützhofen)
Лайпциг (Leipzig)	Вольфганг Тийфензее /ГСДН/ (OB- Wolfgang Tiefensee)
Леверкузен (Leverkusen)	Паул Хеббел /XAX/ (OB- Paul Hebbel)
Любек (Lьbeck)	Бернд Заксе /ГСДН/ (OB- Bernd Saxe)
Людвигсхафен (Ludwigshafen)	Док. Вольфганг Шульте /ГСДН/ (OB- Dr. Wolfgang Schulte) /2002 оны 1 дүгээр сарын 1-нээс Док. Эва Лоозе /Dr. Eva Lohse/ XAX)
Магдебург (Magdeburg)	Док. Лутц Трюмпер /ГСДН/ (OB- Dr. Lutz Trümper)
Майнц (Mainz)	Енс Бойтел /ГСДН/ (OB- Jens Beutel)
Маннхайм (Mannheim)	Герхард Виддер /ГСДН/ (OB- Gerhard Widder)
Мөэрз (Moers)	Рафаел Хофманн /XAX/ (B-Rafael Hofmann)
Мөнхенгладбах (Mönchengladbach)	Моника Бартш /XAX/ (OB- Monika Bartsch)
Мюльхайм/Руур (Mülheim a.d. Ruhr)	Док. Енс Баганц /XAX/ (OB- Dr. Jens Baganz)
Мюнхен (München)	Кристиан Уде /ГСДН/ (OB- Christian Ude) Гертрауд Буркерт /ГСДН/ (Stellv. und 2. B- Dr. Gertraud Burkert) Хен Монатцедер /Холбоо 90/Ногоонтны нам (3. B- Hen Monatzeder)
Мюнстер (Münster)	Док. Бертольд Тилманн /XAX/ (OB- Dr. Berthold Tillmann)
Нойс (Neuss)	Херберт Нapp /XAX/ (B- Herbert Napp)

Нюрнберг (Nürnberg)	Людвиг Шольц /ХНХ/ (OB- Ludwig Scholz)
Оберхаузен (Oberhausen)	Буркард Дрешер /ГСДН/ (OB- Burkhard Drescher)
Офенбах/Майн (Offenbach a.M)	Герхард Грандке /ГСДН/ (OB- Gerhard Grandke)
Олденбург (Oldenburg)	Док. Юрген Пөшель /ХАХ/ (OB- Dr. Jürgen Pöschel)
Оснабрюк (Osnabrück)	Ханс-Юрген Фип /ГСДН/ (OB- Hans-Jürgen Fip)
Падерборн (Paderborn)	Хайнц Пауз /ХАХ/ (OB- Heinz Paus)
Пфорцхайм (Pforzheim)	Кристел Аугенштайн /ЧАН/ (OB- Christel Augenstein)
Потсдам (Potsdam)	Маттиас Платцек /ГСДН/ (OB- Matthias Platzek)
Реклингхаузен (Recklinghausen)	Вольфганг Пантфөрдер /ХАХ/ (B- Wolfgang Pantförder)
Регенсбург (Regensburg)	Ханс Шайдингер /ХНХ/ (OB- Hans Schaidinger)
Ремшайд (Remscheld)	Фред Шульц /ХАХ/ (OB- Fred Schulz)
Ройтлинген (Reutlingen)	Док. Стефан Шультеc /ХАХ/ (OB- Dr. Stefan Schultes)
Росток (Rostock)	Арно Пөкер /ГСДН/ (OB-Arno Pöker)
Заарбрюкен (Saarbrücken)	Хаёо Хофманн /ГСДН/ (OB- Hajo Hoffmann)
Залцгиттер (Salzgitter)	Рудольф Рюекерт /ХАХ/ (OB- Rudolf Rueckert)
Шверин (Schwerin)	Йоханнес Квашик /ГСДН/ (OB- Johannes Kwaschik)
Зийген (Siegen)	Ульф Штөцел /ХАХ/ (B- Ulf Stötzel)
Золинген (Solingen)	Франц Хауг /ХАХ/ (OB- Franz Haug)
Штутгарт (Stuttgart)	Док. Вольфганг Шустер /ХАХ/ (OB- Dr. Wolfgang Schuster)
Улм (Ulm)	Иво Гөннер /ГСДН/ (OB- Ivo Gönner)
Вийзбаден (Wiesbaden)	Хильдебранд Дийл /ХАХ/ (OB- Hildebrand Diehl)
Виттен (Witten)	Клаус Лооманн /ГСДН/ (B- Klaus Lohmann)

Эх сурвалж: Deutscher Städtetag

**Сонгож авсан том хотууд  
болон хороодын өрийн дарамт**

(1999оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)


<b>Хотын ангилал</b>	<b>Хотын нэр</b>	<b>Өрийн хэмжээ /оршин суугч бүрд ноогдох өр ДМ-ээр/</b>
<b>500.000 дээш хүн амтай хотууд</b>	Франкфурт/Майн	6667
	Дюзельдорф	5401
	Кельн	5006
	Дуисбург	4118
	Мюньхен	3480
	Эссэн	3347
	Ханновер	3220
	Дортмунд	2993
	Штуттгарт	2836
<b>200.000 дээш хүн амтай хотууд:</b>	Бонн	5726
	Аахен	4867
	Бийлефельд	4555
	Любек	4171
	Лайпциг	3583
	Бохум	3524
	Нюрнберг	3442
	Дрезден	3410
	Оберхаузен	3383
	Крефельд	3313
	Кийл	3296
	Фрайбург/Брийзгау	3175
	Мөнхеньгладбах	3057
	Мюнстер	2970
	Вийзбаден	2810
	Брауншвайг	2735
	Хемнитц	2677
	Хаген	2477
	Маннхайм	2454
	Гельзинкирхен	2152
Халле	2124	
Аугсбург	2123	
Карлзруэ	2091	
Эрфурт	2048	

## Хүн ам, эдийн засаг, нийгмийн бүтэц, зохион байгуулалтын тухай бусад тоо баримтууд

### Хүн ам

Холбооны Статистикийн Албаны мэдээгээр *Германы хүн ам* 2000 оны 6 дугаар сарын 30-нд (1999 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар) 82.182.824 (82.163.475)-д хүрсний 42.067.206 (42.078.699) нь эмэгтэйчүүд, 40.115.618 (40.090.776) нь эрэгтэйчүүд байв. Үүнээс 67.008.472 (66.946.150) нь баруун Германд, 15.174.352 (15.217.325) нь зүүн Герман болон зүүн Берлинд амьдарч байлаа. 1999 онд хүн амын үзүүлэлтүүд ямар байв, мөн 2050 он хүртэл эдгээр үзүүлэлтүүд ямар байхыг авч үзье.

**2050 он хүртэлхи хүн амын хөгжил**  
(саяар)



Эх сурвалж: Холбооны Статистикийн алба, Вийзбаден

Цагаачлан ирэгсэд нэмэгдсэнтэй холбогдож **хүн ам ялимгүй өсч байна. Амьд төрсөн хүүхдийн тоо** 1999 онд 770.744 хүрснээс 396.296 нь эрэгтэй хүүхэд байсан бөгөөд (1998 онд энэ тоо 785.034 байснаас 402.865 нь эрэгтэй) үүнээс 95.216 (1998 онд 100.057) нь буюу 12,4% (12,7%) нь гадаад иргэдийн хүүхдүүд байв. 1999 онд гэр бүлгүй эмэгтэйчүүдээс төрсөн хүүхдийн тоо 170.634 (1998 онд

157,117) байгаа нь тухайн онд төрсөн бүх хүүхдийн 22,1% (20,0%) болж байв. Холбооны Статистикийн Албаны мэдээгээр баруун Германд эрэгтэйчүүдийн дундаж наслалт одоогийн байдлаар 74,78 жил; эмэгтэйчүүдийнх 80,72 жил байна. Харин зүүн Берлин болон зүүн Германд дундаж наслалт эрэгтэйчүүдийн хувьд 73,01 жил; эмэгтэйчүүдийн хувьд 79,96 жил байна.

**Нас барагсдын тоо** 1999 онд 846.330 хүрснээс (1998 онд энэ тоо 852.382) 14.305 нь (1998 онд 13.758) гадаад иргэд байв. Ийнхүү нас баралт 1999 онд төрөлтөөс 75.586 (1998 онд 67.348)-аар илүү байснаас баруун Германы муж улсуудад 21.027 (1998 онд 5946) бол зүүн Германд 54.559 (1998 онд 61.402) хүрч илтэд өндөр байсан нь тэнд төрөлт баруун Германыг бодвол харьцангуй бага байсантай холбоотой юм.

2000 оны 4 дүгээр сарын байдлаар Германд 22,423 сая (1999 онд 22,405 сая) **гэр бүл** байснаас 12,823 сая (12,913 сая) нь хүүхэдтэй гэр бүл байв. Өрх толгойлж буй ганц бие эцэг эхчүүд (үүнд мөн батлуулаагүй боловч хамтран амьдрагч нарыг оруулсан болно) 2,968 сая (2,926 сая) байгаагаас 0,533 сая (0,512 сая) нь эрэгтэйчүүд, 2,435 сая (2,494 сая) нь эмэгтэйчүүд байв.

1999 онд 430.674 (1998 онд 417.420) гэр бүл шинээр бүртгэгдсэн нь урьд оныхоос 13.229-ээр илүү байлаа. Эдгээр шинэ гэр бүлийн 370.171 (362.548) нь Баруун Германд, 60.503 (54.872) нь Зүүн Германд тус тус ноогдож байна.

Баруун, Зүүн Германы (Зүүн Берлинийг оролцуулан) муж улсуудын хооронд **шилжилт хөдөлгөөн** мөн л үргэлжилсээр байна. Холбооны Статистикийн Албаны явцын мэдээгээр 1999 онд Зүүн Германаас Баруун Германд шилжин суурьшигсдын тоо 195.530 (1998 онд 182.478, 1990 онд 395.343)-д хүрсэн бол харин Баруун Германаас Зүүн Германд шилжин суурьшигсдын тоо 151.943 (1998 онд 151.750, 1990 онд 36.217) болжээ.

### **Харьяалал**

1999 онд 248.206 (1998 онд 291.331) хүн Германы харьяат болсон бөгөөд энэ нь түрүү жилийнхээс 43.125 хүнээр буюу 14,8%-

иар бага байна. Гадаадын иргэдийн тухай хуулийн 85, 86 дугаар зүйлийн нэгдүгээр хэсгийн дагуу (Германд олон жил суусан гадаадын иргэд ба гадаадын залуу хүмүүсийн хувьд) Германы харъяат болох эрхтэй гадаадын иргэдэд харъяалал олгосон болон нөхцөл байдлыг харгалзан үзэж 1999 онд Германы харъяат болгосон 143.267 (1998 онд 106.790) гадаад иргэдийн 103.900 (59.664) нь турк, 4980 (5000) нь марокко, 3835 (1349) нь румын, 3608 (2432) нь югослав, 2865 (1936) нь польш, 2597 (3595) нь вьетнам, 1648 (2202) нь хорват, 1456 (1894) нь тунис хүмүүс байв. Үүнээс 14% орчим нь буюу бусад улсад давхар харъяалал бүхий 19.721 хүнд германы харъяаллыг олгосон байна.

**Гадагшаа гарсан германчуудаас** 2000 онд урьд оныхоос (1999 онд 104.916) арай цөөн буюу 95.615 нь нутагтаа эргэн иржээ. Холбооны Захиргааны Албаны мэдээгээр 2000 онд хуучин ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудаас 94.558 (103.599) Румынаас 547 (855), Польшоос 484 (428), бусад улсуудаас 26 (34) герман тус тус нутагтаа буцаж ирсэн байна.

**1990-2000 онд гадаад улсуудаас эх орондоо эргэн ирсэн германчуудын тоо**

(1950 оноос хойш нийт 4.124.482 герман)

1990 онд – 397.073	1996 онд – 177.751
1991 онд – 221.995	1997 онд – 134.419
1992 онд – 230.565	1998 онд – 103.080
1993 онд – 218.888	1999 онд – 104.916
1994 онд – 222.591	2000 онд – 95.615
1995 онд – 217.898	

Эх сурвалж: Холбооны Захиргааны Алба 2001 он

ХБНГУ дахь гадаадын иргэдийн тоо 2000 онд 0,6%-иар (1999 онд 0,3%-иар өссөн) өссөн байна. 2000 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 7.296.817 (1999 онд 7.343.591) гадаад иргэн Германд байр сууцтай гэж бүртгүүлсэн байх бөгөөд үүний 3.959.290 (4.011.890) нь эрэгтэйчүүд, 3.337.527 (3.331.701) нь эмэгтэйчүүд байв.

**Гадаад иргэд муж улсуудад байршсан байдлыг  
статистикийн тооцоогоор авч үзвэл:**

Муж улсуудын нэр	2000 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	1999 оны байдлаар
Нордрайн- Вестфален	1.957.341	2.044.625= 11,4%
Баден-Вюрттемберг	1.249.370	1.305.175=12,5%
Бавари	1.117.412	1.123.257= 9,2%
Хөссен	840.244	730.507= 12,1%
Борлин	483.581	433.562= 12,8%
Нийдерзаксен	473.516	527.802= 6,7%
Хамбург	333.568	261.871= 15,4
Райнланд- Пфайльц	297.076	311.688= 7,7%
Шлесвиг-Хольштайн	141.371	151.621= 5,5%
Заксен	83.958	104.970= 2,4%
Бремен	81.090	101.492= 15,3%
Зарланд	80.217	88.348= 8,2%
Заксен-Анхальт	48.954	44.154= 1,7%
Бранденбург	48.804	61.179= 2,4%
Тюринген	32.134	41.673= 1,7%
Мекленбург-Порфоммерн	28.181	31.651= 1,8%

Германы хүн амын дотор **нийт гадаад иргэдийн эзлэх хувь** 2000 оны 12 дугаар сарын 31-нд 8,9%-д хүрсэн. (1999 онд 9.0%-тай байв) Энэ тоог бусад оронтой харьцуулбал: Австрид 2000 онд 9,4%; 1999 онд 9,3%; Швейцарид 2000 онд 19,7%; 1999 онд 19,6% байлаа.

**Герман дахь гадаад иргэд  
(50мянгаас дээш тоо бүхий)**

Харьяат улсын нэр	2000 оны эцсээр	1999 оны байдлаар
Турк	1.998.534	2.053.564
Холбооны Бүгд Найрамдах Югослав	662.495	737.204
Итали	619.060	615.900
Грек	365.438	364.354
Польш	301.366	291.673
Хорват	216.827	213.954
Австри	187.742	186.090

Холбооны Дотоод Явдлын Яамны мэдээлснээр 2000 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 1,1 сая **дүрвэгсэд** (Женевын конвенцийн дагуу авч үзвэл дүрвэгсдийн статустай болон статусгүй) ХБНГУ-д байрлаж байснаас

- 164.000 нь орогнол эдлэгсэд ба гадаад улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн дүрвэгсэд,
- 130.000 нь орогнол эдлэгсдийн гэр бүл,
- 54.000 нь конвенцийн хүрээнд дүрвэгсэд,
- 8.000 хүмүүнлэгийн тусламж болгон гамшиг тохиолдсон орноос тогтоосон тоо хэмжээний дагуу хүлээн авсан дүрвэгсэд,
- хуучин ЗХУ-аас цагаачлагч 137.000 еврэй,
- 13.000 харъяалалгүй хүмүүс,
- 200.000 орогнол эрэгсэд,
- 30.000 Босни-Герцоговина дахь дотоодын (иргэний) дайнаас зугатан дүрвэгсэд,
- 370.000 Дефакто-дүрвэгсэд байв.

### Боловсрол

1999 онд нийтийн боловсролд зориулж 153,409 (1998 онд 150,997) млрд ДМ-ийг зарцуулсан бөгөөд үүний 10,734 (10,282)-ийг холбооны улс, 113,050 (111,214) муж улсууд, 29,625 (29,501) млрд ДМ-ийг хороод болон тусгай зорилго бүхий хороодын холбоод бүрдүүлсэн байна. Үүнийг салбар бүрээр нь авч үзвэл:

- бага сургуулиуд, сургуулийн бус замаар хүүхэд, залуучуудад боловсрол олгох— 14,454 (1998 онд 14,427) млрд ДМ
- сургуулиуд— 88,407 (87,261) млрд ДМ
- их, дээд сургуулиуд— 31,587 (30,735) млрд ДМ
- мэргэжил дээшлүүлэх— 4,348 (4,247) млрд ДМ
- дэмжлэг үзүүлэх арга хэмжээ— 5,623 (5,780) млрд ДМ
- хамтарсан судалгаа, шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх— 8,990 (8,547) млрд ДМ

Боловсрол, судалгаа, шинжлэх ухаанд зарцуулах төсөв нь боловсрол, судалгаа, шинжлэх ухаанд зориулж макро эдийн засгийн үүгээс энэ салбарт гаргах бүх зардал гэсэн үг юм. Боловсролд зарцуулсан хөрөнгө 1999 онд 220,0 (1998 онд 216,7) млрд ДМ болсон бөгөөд мөн үүнээс гадна

- суралцагчдыг дэмжих зорилгоор 21,7 (20,6) млрд ДМ;
- судалгаа, техникийн хөгжил, дэвшилд 94,4 (87,3) млрд ДМ;
- боловсрол, шинжлэх ухааны бусад дэд бүтцийг хөгжүүлэхэд 8,2 (8,2) млрд ДМ-ийг оролцуулаад боловсрол, судалгаа, шинжлэх ухаанд зориулах нийт зардал 344,3 (332,8) млрд ДМ болсон байна.

2000-2001 оны хичээлийн жилд (явцын мэдээгээр) 9,966 (1999-2000 оны хичээлийн жилд 10,050) сая **сурагчид** (4,9 сая нь эмэгтэй, 5,1 сая нь эрэгтэй) ерөнхий боловсролын сургуульд сурсан бөгөөд үүнээс мөн хэдэн мянга нь сургуулийн өмнөх насныхны сургалт (Бэлтгэл анги буюу сургалт бүхий цэцэрлэг)-нд хамаарагдах юм. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдыг дотор нь задлан авч үзвэл:

- бага анги (бага сургуулиуд, нэгдсэн цогцолбор сургууль буюу чөлөөт Вальдорф сургуулиуд) - 67,6 (69,3) мянган сурагч

- дунд анги (мэргэжлийн чиг олгох төрөлжсөн бус сургалт, дунд сургууль, мэргэжлийн чиг бүхий дунд сургууль, хэд хэдэн сонгон хичээл бүхий сургуулийн төрлүүд, нэгдсэн цогцолбор сургууль буюу Вальдорф сургуулиуд, оройн дунд сургууль, мэргэжлийн чиг бүхий оройн дунд сургууль, гимнази) - 3396 (3533) мянган сурагч

- ахлах анги (гимнази, нэгдсэн цогцолбор сургууль буюу Вальдорф сургуулиуд, оройн гимнази буюу элсэлтийн шалгалтанд бэлтгэх сургалт) - 5329 (5267) мянган сурагч

- тусгай сургуулиуд – 420 (416) мянган сурагч

2000-2001 оны /явцын мэдээгээр/ өвлийн семестерт суралцсан **оюутны** тоог түрүү жилийн мөн үеийнхтэй харьцуулбал 1,4%-иар өсч 1.798.517-д хүрсэн байна. Эрэгтэй оюутны тоо 285-аар буурсан байхад эмэгтэй оюутны тоо 24.846 (3,1%) -аар нэмэгдсэн байна. 2000 онд (2000 оны зуны семестер ба 2000-2001 оны өвлийн семестер) их дээд сургуульд элсэгчдийн тоо 1999 оныхтой харьцуулахад 7,3%-иар өсөж, 312.806 болсон байна.

- Бүх оюутнуудын 1.169.303 нь их сургуулиудад (сурган хүмүүжүүлэх болон онолын дээд сургуулиудыг оролцуулаад)

- 139.252 нь цогцолбор дээд сургуулиудад

- 30.499 нь урлагийн дээд сургуулиудад

- 426.841 нь ерөнхий мэргэжлийн дээд сургуулиудад

- 32.622 нь захиргааны мэргэжлийн дээд сургуулиудад тус тус

суралцаж байна.

- Оюутнуудыг суралцаж буй хичээлийн төрлүүдээр жагсаавал:
- эрх зүй, эдийн засаг, нийгмийн ухааны чиглэлээр – 572 мянга
  - хэл, соёлын шинжлэх ухааны чиглэлээр - 399 мянга
  - инженерийн чиглэлээр- 292 мянга
  - математик, байгалийн шинжлэх ухаан – 290 мянга
  - анагаах ухаан - 94 мянга
  - урлаг, урлахуйн ухаан – 79 мянга
  - газар тариалан, ой судлал, хоол судлалын ухаан – 35 мянга
  - спорт - 27 мянга
  - мал эмнэлэг – 8 мянга
  - бусад чиглэлээр – 3 мянга

2000-2001 оны өвлийн семестерт суралцаж буй оюутнуудынх нь тоогоор их, дээд сургуулиудыг жагсаан бичвэл:

1. Кельний их сургууль – 60.357
2. Цогцолбор дээд сургууль/ Хагений зайны сургалттай их сургууль - 46.760
3. Мюнстерийн их сургууль - 42.934
4. Мюньхений Людвиг-Максимиланы их сургууль – 41.943
5. Берлиний Чөлөөт их сургууль – 41.382
6. Хамбургийн их сургууль – 37.927
7. Франкфурт/Майны их сургууль – 37.185
8. Бонны их сургууль – 36.907
9. Берлиний Хумбольдтын их сургууль – 34.423
10. Бохумын их сургууль – 34.033
11. Майнцын их сургууль – 27.970
12. Берлиний техникийн их сургууль – 27.768
13. Аахены техникийн дээд сургууль – 27.397
14. Ханноверийн их сургууль - 26.023
15. Дюсельдорфийн их сургууль – 24.855

**Мэргэшил эзэмших сургалтын байр эрж хайгсдын** хувьд байдал 2000 онд баруун, зүүн Германд тун ялгаатай байсан бөгөөд зүүн Германд Холбооны хөдөлмөрийн албанд ирүүлсэн мэргэшил эзэмшүүлэх 127.000 (1999 онд 138.000) сургалтын орон тоонд 224.000 (235.000) хүн өрсөлдсөн байна. Үйлдвэрлэлийн бус замаар мэргэшил эзэмшүүлэх орон тоо (1999 онд 87.000, 2000 онд 88.000) ч дээрхи тэнцвэргүй байдлыг арилгаж чадсангүй.

Харин баруун Германд 546.000 (568.000) хүн 498.000 (1999 онд 491.000) мэргэшил эзэмших сургалтын байрны төлөө өрсөлдсөн байна.

### Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн статистик (уг статистик нь Холбоо, муж улсуудын дотоод явдлын сайд нарыг хариуцах ажлын хүрээнд багтдаг)-ийн дагуу 2000 онд нийт 6.264.723 (1999 онд 6.302.316) гэмт хэрэг бүртгэгдсэн нь 1999 оныхтой харьцуулбал 0,6%-иар буурсан байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийг прокурорын газар шилжүүлдэг бөгөөд энэ тоо нь Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн хэргийн статистикаас зөрдөг. Учир нь хууль шүүхийн байгууллагуудаар шийдвэрлэгдсэн хэргийн тоо ямагт арай цөөхөн гардаг. Бүртгэгдсэн гэмт хэргүүдээс үзэхэд мансууруулах бодис, залилангийн гэмт хэрэг, эдийн засгийн гэмт хэрэг, хууль бус дампуурлын гэмт хэрэг өсөж, харин хулгай, хүрээлэн буй орчинд хохирол учруулсан гэмт хэрэг буурсан байна.

Гэмт хэргийн бүртгэлээс харахад Бременд 7,1%; Шлесвиг-Хольштайнд 3,6%; Заарландад 3,4%; Бранденбургт 1,8%; Хамбургт 1,1%; Райнланд-Пфальц-д 1,0%-иар гэмт хэрэг тус тус өссөн бөгөөд харин бусад муж улсуудад буурсан ажээ.

Хулгайн гэмт хэрэг урьдын адил гэмт хэргийн 47,7%-ийг (1999 онд 49,7%) эзэлж 2.983.269 үйлдэл буюу хамгийн их үйлдэгдсэн гэмт хэргээр тодорч байна. Харин үүнд механикжсан тээврийн хэрэгслийн хулгайн гэмт хэргийг бүртгүүлсэн тохиолдол 11,4%-иар буурсан байна. Урьд жилийнхтэй харьцуулахад орон байрны хулгайн гэмт хэргийг бүртгүүлсэн тохиолдол 6,1%-иар буурсан байна.

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн 187.103 тохиолдол 2000 онд бүртгэгдсэн нь 1999 оныхоос 0,2%-иар өссөн байна. Хүний биед хүнд, ноцтой гэмтэл учруулсан гэмт хэрэг 2,1%-иар өсөж, дээрэм болон хүн амины хэрэг 3,3%; 2,8%-иар тус тус буурсан байна.

Эдийн засгийн гэмт хэрэг 2000 онд 90.706 (урьд жилийнхээс 16,7%-иар буурсан байна) бүртгэгдсэн хэдий ч огт бүртгэгдээгүй энэ төрлийн гэмт хэрэг нэлээд бий. Мөн цагдаа, татварын газрын оролцоогүйгээр Улсын прокурорын тусгай албад биечлэн шууд мөрдсөн хэргүүд дээр дурдсан статистикт ороогүй болно.

Хүрээлэн буй орчинд хохирол учруулсан гэмт хэрэг (үүнд газрын хэвлийг бохирдуулсан үйлдэл мөн орно) 6,1%-иар буурч,

34.415 тохиолдол бүртгэгджээ. Байгаль орчинд халтай байдлаар хог хаягдлаа хаясан гэмт хэргийн 24.190 тохиолдол бүртгэгдсэн нь энэ төрлийн гэмт хэргийн ихэнхийг эзэлж байна.

Компьютер дээр үйлдсэн гэмт хэрэг 2000 онд 56.699 (1999 онд 45.359) бүртгэгджээ. Хууль бус картаар автомат касснаас мөнгө залилан авах явдал 44.284 удаа бүртгэгдсэн нь 21,0%-иар өсчээ.

1999 онд 816 (1998 онд 832) зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдсөн бөгөөд үүнээс 388 хэрэг буюу 47,5% нь Нордрайн-Вестфален, Хессен, Берлин, Баварид гарсан байна. Эдгээр нь хүн ам ихэд төвлөрсөн газрууд учраас ийм байдлыг гэмт хэрэг үйлдэгчид ашиглахыг илүүд үлсэн бололтой. Энэ нь ялангуяа мансууруулах бодисын худалдаа, наймаа (272 хэрэг), аж ахуй, эдийн засгийн шинжтэй гэмт хэрэг (98 хэрэг), өмчтэй холбогдол бүхий гэмт хэрэг (95 хэрэг)-т хамаарах юм. Гэвч хамрах хүрээнээсээ шалтгаалж эдгээр гэмт хэргүүд хосолсон байх нь элбэг бөгөөд үүнд ялангуяа мансууруулах бодисын худалдаа (ихэвчлэн хууль бус зэвсгийн наймаатай холбогддог), шөнийн амьдрал, кучирхийллийн гэмт хэрэг орно. Жишээлбэл өмчтэй холбогдол бүхий гэмт хэрэг, дамын наймаа, хүнийг нууцаар хил давуулсан гэмт хэрэг ихэвчлэн баримт бичгийг хуурамчаар үйлдэх гэмт хэрэгтэй хамт үйлдэгдэх нь байнга тохиолддог. Гэмт хэрэгтнүүд улсад 1,4 млрд орчим ДМ (1998 онд 1,8 млрд ДМ) –ийн хохирол учруулсан бөгөөд тэд 2,0 млрд орчим ДМ-ийн ашиг олсон болохыг тогтоожээ.

2000 онд 3.335.356 гэмт хэргийг илрүүлсэн нь *гэмт хэрэг илрүүлэлтийн төвшин* 53,2%-д (1999 онд 52,8%) хүрч ерөнхийдөө сайжирсан бөгөөд 1966 оноос хойш хамгийн өндөр төвшинд хүрсэн нь энэ ажээ. Гэмт хэрэг илрүүлэлтийн төвшин гэмт хэрэг бүрд тун энэ янз байна.

- хүн амины хэрэг - 95,3%-тай,
- хүний биед хүнд, ноцтой гэмтэл учруулсан гэмт хэрэг - 83,9%
- залилан - 79,9%;
- хүчин, секс халдлагын хэрэг - 79,7%;
- дээрэм - 50,5%;
- хулгайн хөнгөн гэмт хэрэг - 48,7%;
- санаатай гал түймрийн хэрэг - 48,5%;
- эд хөрөнгийн хохирол учруулсан гэмт хэрэг - 26,9%;
- механикжсан тээврийн хэрэгслийн хулгайн гэмт хэрэг - 26,2%;
- хулгайн ноцтой хэрэг - 14,4% (үүнд орон байрны хулгайн хэрэг мөн орно)

Цагдаагийн газрын бүртгэлээс 2000 онд хулгайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг (хууль бус замаар олсон эд хөрөнгийн өртгийг тухайн үеийнх нь ханшаар тооцон гаргавал) нэгтгэж үзэхэд 2.697.797 хулгайн үйлдлээр 4,2 млрд ДМ-ийн эд мөнгөний хохирол учирсан гэсэн тооцоо гарснаас орон байрны хулгайн гэмт хэрэг 566 сая ДМ, механикжсан тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг 365 сая ДМ-ын хохирол учруулжээ. 2000 онд залилангийн 733.888 хэрэг гарч, 4,4 млрд ДМ-ын хохирол учруулсан байна.

### ХБНГУ-ын эдийн засаг

Дэлхийн худалдааны эргэлт нэмэгдсэн, өрсөлдөөн ширүүссэн нь 2000 онд Германы эдийн засгийн хөгжилд ихээхэн эерэг нөлөө үзүүлсэнийг доорхи тоо баримт бэлхэнээ гэрчилнэ. 1995 оны үнийг суурь үнэ болгон авч үзвэл 2000 онд Германы бодит ДНБ 3,0%-иар (1999: +1,6%), нэрлэсэн ДНБ 2,6%-иар (1999: 2,5%) тус тус өссөн үзүүлэлттэй гарсан нь хоёр Герман нэгдсэнээс хойшхи хамгийн сайн үзүүлэлт юм.

Үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглах явдал нэмэгдсэн нь хөдөлмөрийн зах зээл дээр үр ашгаа өгсний дүнд хөдөлмөр эрхлэгчдийн тоо (+1.6%) өсч, харин ажилгүйдлийн төвшин өмнөх жилтэй харьцуулахад буурч 9.6%-д (1999 онд 10.5%-тай байсан) хүрчээ.

Гэвч баруун, зүүн Германы муж улсуудын хоорондын ялгаа улам нэмэгдсээр байна.

Гаднаас орж ирсэн чухал захиалгууд (17,5%-иар өссөн) конъюктурт мөн л шийдвэрлэх гол түлхэцийг өгсөн байхад харин дотоодын эрэлт хэрэгцээ хэр тааруу хэвээр байна. Үүнд газрын тосны үнэ өссөн, еврогийн ханш унасан зэрэг нөлөөлсөн юм.

Үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулах хандлага нэлээд өссөн. 1999 он дуусмагц барилгын салбар дахин бүтэлгүйтсэн бөгөөд хөрөнгө оруулалт урьд жилийн төвшингөөс 3%-иар доогуур байв.

Хувийн хэрэглээ илтэд буурсан. (1999 онд 2,6%-иар өссөн бол 2000 онд 1.6%-иар өссөн) Үүний гол шалтгаан нь газрын тосны үнэтэй уялдаж үнэ ханш нэмэгдсэн явдал юм. Тухайлбал үүнд механикжсан тээврийн хэрэгслийн худалдаа мөн уламжлалт жижиглэн худалдааны хувьд хувийн хэрэглээ илтэд буурсан бол харин зөвхөн телекоммуникац ба хөгжөөн цэнгээх зориулалтын техник хэрэгслүүд, гадаад орнуудад аялан жуулчлах явдал илүү эрэлт хэрэгцээтэй байв.

2000 онд хэрэглээний үнийн индекс 1,9% (1999 онд +0,6%) - ийр өсч, өрхийн хадгаламжийн хувь хэмжээ 9,75% (9,9%) байна.

### Гадаад худалдаа

Холбооны Статистикийн Албаны мэдээгээр импорт 2000 онд (1999) 1064,309 (869,947) млрд ДМ, экспорт 1167,343 (997,488) млрд ДМ-д тус тус хүрсэн байна. Европын Холбооны орнуудаас 2000 онд 551,346 (468,718) млрд ДМ-ийн бараа бүтээгдэхүүнийг импортолж, 659,886 (573,796) млрд ДМ-ийн бараа бүтээгдэхүүнийг экспортолсон байна. 2000 онд ХБНГУ нь 108,540 (105,078) млрд ДМ-ийн ашигтай худалдааг Европын Холбооны орнуудтай хийсэн байна. АНУ-тай хийсэн гадаад худалдааны тэнцэл 1999 онд +28,814 млрд ДМ гарсан бол 2000 онд 28,624 млрд ДМ-ийн ашигтай гарчээ. Харин Японтой хийсэн худалдааны хувьд алдагдал 22,319-өөс 26,224 млрд ДМ хүртэл өссөн байна.

Гадаад худалдааны статистикийг хөтлөх арга барилыг өөрчилсний улмаас төлбөрийн тэнцлийг илтгэсэн тоо баримтууд тун эргэлзээтэй байна. Германы Бундесбанкны мэдээгээр (1999 оноос хойш зөвхөн еврогоор тооцох болсон) гадаад орнуудтай харьцуулахад алдагдал өмнө жилийнхээс илт өсч 16,8 млрд еврогоос 23 млрд еврод хүрсэн байна. Гадаад худалдааны тэнцэл 2000 онд +52,7 млрд евро болсон бол 1999 онд +65,2 млрд евро байжээ. Үйлчилгээний салбарын хувьд гадаад худалдааны тэнцэл 2000 онд (1999) дахин сөрөг дүнтэй гарсан: -44,3 (-41,1). Үүний гол шалтгаан нь аялал жуулчлалын салбарт 29,8 (-28,9) млрд еврогийн алдагдал хүлээсэн явдал юм. Урсгал тэнцэл 27,0 (25,8) млрд еврогийн алдагдалтай гарсан байна.

2000 онд бодит ДНБ 3840,8 млрд ДМ, нэрлэсэн ДНБ 3976,1 млрд ДМ хүрсэн байна.

**ДНБ-ний бүтцэд** салбар тус бүрийн эзлэх хувь хэмжээг нэрлэсэн үнийн дүнгээр жагсаан бичвэл:

1. Хөдөө аж ахуй ба ойн аж ахуй, загас агнуур – 43,57 (1999 онд 42,77) млрд ДМ
2. Үйлдвэрлэлийн салбар (барилгын салбарыг оруулалгүйгээр) - 933,32 (1999 онд 890,27) млрд ДМ
3. Барилгын салбар – 180,44 (1999 онд 191,38) млрд ДМ
4. Гуанз, буудлын үйлчилгээ, худалдаа, зам тээвэр - 638,64 (1999 онд 621,47) млрд ДМ

5. Санхүү, түрээс, аж ахуйн үйлчилгээ - 1127,72 (1999 онд 1093,44) млрд ДМ

6. Нийтийн болон хувийн үйлчилгээ - 780,45 (1999 онд 773,29) млрд ДМ

2000 оны (1999 оны) **ДНБ-ний хэрэглээний** талаар Холбооны Статистикийн Алба дараахь тоо баримтыг дэлгэж байна. Үүнд:

- Өрхийн хэрэглээний зардал 2000 онд өмнөх онтой харьцуулахад нэрлэсэн үнийн дүнгээр 3,0%-иар (1999 онд +2,7) өсч, улмаар 2232,51 (1999 онд 2168,39) млрд ДМ-д хүрчээ. Энэ нь бодит үнийн дүнгээр буюу 1995 оны үнийн дүнгээр 2000 онд 2094,29 (1999 онд 2064,21) млрд ДМ-д хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 1,5%-иар (1999 оныг 1998 онтой харьцуулахад +2,4%) өссөн гэсэн үг.

- Ашгийн бус хувийн байгууллагуудын хэрэглээний зардал 2000 онд өмнөх жилтэй харьцуулахад нэрлэсэн үнийн дүнгээр 5,2% (1999 онд 8,7)-иар өсч 76,54 (1999 онд 72,75) млрд ДМ-д хүрсэн байна. Харин бодит дүнгээр энэ нь 2000 онд 71,03 (1999 онд 67,86) млрд ДМ болж, өмнөх жилтэй харьцуулахад 4,7% (1999 оныг 1998 онтой харьцуулахад 7,2) -иар өсчээ.

- Улсын хэрэглээний зардал өмнөх онтой харьцуулахад 2000 онд нэрлэсэн үнийн дүнгээр 1,7% (1999 онд 2,2)-иар өсч, 750,31 (1999 онд 738,03) млрд ДМ-д хүрсэн байна. Харин энэ нь бодит үнийн дүнгээр 716,67 (1999 онд 706,72) млрд ДМ болж, урьд оныхоос 1,4%-иар өсчээ.

Нийт хөрөнгө оруулалт 1999 онд 2,5%-иар өсч, 827,04 млрд ДМ-д хүрсэн бөгөөд харин 2000 онд өмнөх онтой харьцуулахад нэрлэсэн үнийн дүнгээр 2,9%-иар өсч, 850,67 млрд ДМ-д хүрсэн. Энэ нь бодит үнийн дүнгээр 1999 онд 3,3%-иар өсч, 838,76 млрд ДМ-д хүрсэн бол 2000 онд 2,4%-иар өсч, 858,98 млрд ДМ-д хүрчээ.

ø Тоног төхөөрөмжид хийсэн хөрөнгө оруулалт 2000 онд 9,5% (1999 онд 5,8)-иар өсч, 340,06 (1999 онд 310,44) млрд ДМ-д хүрсэн ажээ. Энэ нь бодит үнийн дүнгээр 339,99 (1999 онд 312,05) млрд ДМ-д хүрч, өсөлт 9,0% (1999 онд +6,7%)-тай байна.

ø Барилга байгууламжид хийсэн хөрөнгө оруулалт 2000 онд нэрлэсэн үнийн дүнгээр 1,8%-иар (1999 онд 0,0%) буурч, 466,30 (1999 онд 475,07) млрд ДМ-д хүрсэн бөгөөд бодит үнийн дүнгээр энэ нь 1999 онд 0,5%-иар өсч, 481,74 млрд ДМ-д харин 2000 онд 2,5%-иар буурч, 469,65 млрд ДМ-д хүрчээ.

ө Бусад хөрөнгө оруулалт 2000 онд нэрлэсэн үнийн дүнгээр 0,7% (1999 онд 8,9%)-иар өсч, 44,31 (1999 онд 41,53) млрд ДМ-д хүрсэн бол бодит үнийн дүн (1995 оны үнийн дүн) -гээр 9,7% (1999 онд +12,4%)-иар өсч, 49,34 (1999 онд 44,97) млрд ДМ-д хүрсэн байна.

### **2000 онд Үндэсний орлогыг хуваарилсан байдал:**

- Ажиллагсдын цалин хөлс (хөлсний ажлаас олсон орлого үүнд ажил олгогчдын төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг оролцуулан тооцно) 2121,48 (1999 онд 2060,29) млрд ДМ

- Аж ахуйн нэгж, өмчийн орлого 824,14 (1999 онд 810,93) млрд ДМ; Энэ хоёрын нийлбэр Үндэсний Орлогын хэмжээ 2945,62 млрд ДМ болж байгаа бөгөөд энэ нь 1999 онтой (2871,22 млрд ДМ) харьцуулахад 2,6%-иар (1999 оныг 1998 онтой харьцуулахад 1,4%-иар) өссөн байна.

Дотооддоо ажиллагсдын цалин хөлс (хөлсний ажлаас олсон орлого) нь Холбооны Статистикийн Албаны мэдээгээр 2000 онд нийт 2123,61 млрд ДМ (1999 онд 2062,25 млрд ДМ) болж байгаа бөгөөд үүнээс:

- 19,74 (1999 онд 18,93) млрд ДМ нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас ан агнуурын салбарт;

- 639,72 (1999 онд 622,83) млрд ДМ нь үйлдвэрлэлийн салбарт (барилгын салбарыг оруулалгүйгээр);

- 127,11 (1999 онд 129,25) млрд ДМ нь барилгын салбарт;

- 423,67 (1999 онд 413,10) млрд ДМ нь гуанз, буудлын үйлчилгээ, худалдаа, зам тээвэрт;

- 315,22 (1999 онд 292,24) млрд ДМ нь санхүү, түрээс, аж ахуйн үйлчилгээнд;

- 598,15 (1999 онд 585,90) млрд ДМ нь нийтийн болон хувийн үйлчилгээнд тус тус ноогдож байна.

Германы Бундесбанкны явцын мэдээгээр (ESVG'95-ын дагуу мөнгөн хөрөнгийн шинэчилсэн тооцоог ашигласан) өрхийн нийт мөнгөн хөрөнгө 2000 оны эцэс гэхэд 7127 (1999 онд 7034) млрд ДМ болжээ. Үүнд:

- Банкинд байршуулсан мөнгөн хадгаламж 2415 (1999 онд 2476) млрд ДМ, үүнээс:

o 1801 (1999 онд 1883) млрд ДМ нь богино хугацааны мөнгөн хадгаламж,

○ 614 (1999 онд 593) млрд ДМ арай урт хугацааны мөнгөн хадгаламж байв.

- 1696 (1999 онд 1575) млрд ДМ даатгал,

- 2637 (1999 онд 2624) млрд ДМ үнэт цаас, үүнээс 816 (1999 онд 896) млрд ДМ нь акциар тус тус байна.

Өрхийн нийт өр 2000 онд 2929 (1999 онд 2844) млрд ДМ-д хүрсэн байна. 2000 онд хувийн хадгаламж 250,3 (1999 онд 247,2) млрд ДМ-д хүрч, хадгаламжийн квот 9,75% (1999 онд 9,9)-д хүрсэн байна.

### Хөдөлмөр ба Нийгмийн асуудал

2000 оны дунджаар хөдөлмөрийн чадвартай хүмүүсийн тоо явц дундын хянасан дүнгээр 41.711.000 (1999 онд 39,604)-д хүрчээ. 2000 онд /дотоодын/ хөдөлмөр эрхлэгчдийн тоо 38.466.000 (1999 онд 36,041) -д хүрсний 3.944.000 (1999 онд 4,012)-ыг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон түүнд хамжин туслагч гэр бүлийн гишүүд эзэлж байна. Хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн тоо 1999 оны 4 дүгээр сарын байдлаар 15.745.000-д хүрсэн нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн төвшин 57,0% болж байна.

2000 онд дотооддоо хөдөлмөр эрхлэгчдийн тоог (явц дундын хянасан дүнгээр) эдийн засгийн салбар тус бүрээр үзүүлбэл:

- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур - 977.000 (1999 онд 0,968)

- Үйлдвэрлэлийн салбар (барилгын салбарыг оролцуулалгүйгээр) - 8.571.000 (1999 онд 8,377)

- Барилгын салбар - 2.741.000 (1999 онд 2,757)

- Гуанз, буудлын үйлчилгээ, худалдаа, зам тээвэр - 9.679.000 (1999 онд 8,783)


- Санхүү, түрээс, аж ахуйн үйлчилгээ - 5.608.000 (1999 онд 4,662)

- Нийтийн болон хувийн үйлчилгээ - 10.956.000 (1999 онд 10,559)

Германы Гар Урчуудын Төв Холбооноос 2000 оны 12 дугаар сарын 31-нд хийсэн тооллогын дүнгээр Германд 682.151 (1999 онд 685.456) гар урлалын үйлдвэр ажиллаж байв.

### Хувийн байрны ашиглалт

Эзэмшигч нь өөрсдөө суудаг орон байрны эзлэх хувь



Эх сурвалж: Холбооны Статистикийн Алба, Вийзбаден, 1998 оны байдлаар

**Гар урлал: Аж ахуйн нэгж, ажиллагсад, гүйлгээ**

Аж ахуйн нэгжийн тоо	Ажиллагсдын тоо /мянгаар/	Гүйлгээ /тэрбум ДМ-ээр/
1994 онд – 593.700	1994 онд – 6300	1994 онд – 974,6
1995 онд – 597.800	1995 онд – 6292	1995 онд – 978,1
1996 онд – 600.800	1996 онд – 6186	1996 онд – 972,1
1997 онд – 604.000	1997 онд – 6067	1997 онд – 977,2
1998 онд – 611.800	1998 онд – 5900	1998 онд – 979,7
1999 онд – 610.600	1999 онд – 5706	1999 онд – 996,6
2000 онд – 607.600	2000 онд – 5523	2000 онд – 989,4

Эх сурвалж: Германы гар урчуудын төв холбоо, Холбооны Статистикийн алба, Вийзбаден (мэдээллийн зарим хэсэгт анализ хийгдсэн)

2000 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар **төрийн байгууллагад ажиллагсад** 4.911.217 (1999 оны байдлаар 4.967.892) байгаагийн 3.701.127 (1999 оны байдлаар 3.805.001) нь ажлын бүтэн цагаар ажилладаг, 1.210.090 (1999 оны байдлаар 1.162.891) нь ажлын хагас цагаар ажиллаж байв. Бүх ажиллагсдын 15,5% (15,9%) нь төрийн байгууллагад ажиллаж байгаа нь 1998 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдалтай харьцуулахад 0,4% (0,3%)-иар буурсан байна.

Төрийн байгууллагад ажиллагсдаас 4.424.206 нь (4.510.809) шууд төрийн байгууллагад ажиллаж буй бөгөөд үүнээс:

- 502.020 (510.219) нь холбооны улсын байгууллагад,
- 2.274.848 (2.312.103) нь муж улсуудад,
- 1.503.946 (1.537.379) нь хороод болон тэдгээрийн холбоодод
- 69.773 (72.676) нь тусгай зорилго бүхий хороодын холбоодод
- 73.619 (78.432) нь холбооны төмөр замын санд ажиллаж байв.

Харин үлдсэн 487.011 нь (457.083) шууд бус төрийн байгууллагад ажиллагсад бөгөөд үүнийг задлан авч үзвэл:

- 232.710 (233.251) нь холбооны улсын байгууллагад
- 254.301 (224.832) нь муж улсын төрийн байгууллагад ажиллаж байна.

Төрийн байгууллагад ажиллагсдыг хашиж буй албан ажлаар нь авч үзвэл албан хаагч 2.355.803 (2.372.183), ажилчид 686.904 (712.190), төрийн албан хаагч, шүүгч, цэрэг бүгд 1.868.510 (1.883.519) /үүнээс 186.560 (189.760) нь цэрэг/ байна.

Хөдөлмөрийн зах зээл дээр Германы баруун, зүүн муж улсуудад байдал маш их ялгаатай байсан. Хөдөлмөрийн чадвартай хүмүүсийн тоотой харьцуулахад хамгийн олон ажилгүйчүүдтэй муж улсууд бол 2001 оны 6 дугаар сарын байдлаар Заксен-Анхальт, Мекленбург-Форпоммерн, Бранденбург байлаа. 2000 оны дундаж үзүүлэлтээр 3.888.652 (1999 онд 4.099.200) ажилгүйчүүд байсан буюу ажилгүйдлийн төвшин (бүх ажил эрхлэгчдийн тоонд ажилгүйчүүдийн эзлэх хувь хэмжээ) 9,6% (1999 онд 10,5%)-тай байна. 2001 оны 6 дугаар сард 3.694.363 (3.724.330) тооны ажилгүйчүүд байсан ба ажилгүйдлийн төвшин 8,9%-тай байлаа.

Холбооны Хөдөлмөр зохицуулалтын албанаас гаргасан мэдээгээр 2000 онд **Баруун Германы муж улсуудад ажилгүйчүүдийн тоо** урьд жилийнхээс цөөн байна. Тоо баримтыг дурдвал 2000 онд 2,529 (2,756) сая ажилгүйчүүд байгаагаас 1,398 (1,536) сая нь эрэгтэйчүүд, 1,131 (1,220) сая нь эмэгтэйчүүд байв. Ажилгүйчүүдийн 67 (70) мянга нь 20-иос доош насны залуучууд, 437 (478) мянга нь гадаад иргэд, 146 (157) мянга нь хүнд бэртэлтэй тахир дугуу хүмүүс байв. 2000 оны дундаж дүнгээр ажилгүйдлийн төвшин 7,8% (1999 онд 8,8%)-тай байжээ. Ажлын хагас цагаар хөдөлмөр эрхлэгчдийн тоо 62 (92) мянга болтлоо буурсан. Ажлын байр шинээр бий болгох арга хэмжээнд 2000 онд 58 (1999 онд 66) мянган хүн хамрагдсан бөгөөд Хөдөлмөр зохицуулалтын албанаас санхүүжүүлсэн мэргэжил дээшлүүлэх арга хэмжээнд 338 мянган хүн хамрагджээ.

**Зүүн Германы муж улсуудад ажилгүйчүүдийн тоо** 2000 онд өсч 1,359 (1999 онд 1,344) сая-д хүрсэн бөгөөд үүнээс 625 (655) мянга нь эрэгтэйчүүд, 719 (705) мянган эмэгтэйчүүд байв. Ажилгүйчүүдийн 34 (32) мянга нь хориос доош насны залуучууд, 34 (32) мянга нь гадаадын иргэд, 38 (36) мянга нь хүнд бэртэлтэй тахир дутуу хүмүүс юм. 2000 оны дундаж дүнгээр ажилгүйдлийн төвшин 17,4% (1999 онд 17,6%)-тай байжээ. Ажлын хагас цагаар хөдөлмөр эрхлэгчдийн тоо 24 (27) мянга байв. Ажлын байр шинээр бий болгох арга хэмжээнд 2000 онд 146 (1999 онд 168) мянган хүн хамрагдсан бөгөөд Хөдөлмөр зохицуулалтын албанаас санхүүжүүлсэн мэргэжил дээшлүүлэх арга хэмжээнд 213 мянган хүн хамрагджээ.

**Герман дахь ажилгүйчүүдийн тоо, ажлын сул байр,  
ажилгүйчүүдэд зуучилсан байдал 1992-1996 онд**

	1992	1993	1994	1995	1996
Ажилгүйчүүд (саяар)	3,0	3,4	3,7	3,6	4,0
Ажлын сул байр (мянгаар)	356	279	285	321	327
Ажилгүйчүүдэд ердийн байдлаар ажлын байр зуучилсан нь	2170451	2108681	2347175	2435131	2529384
Ажлын байр бий болгох арга хэмжээний хүрээнд зуучилсан нь	376451	305877	389170	310036	324380

Эх сурвалж: Холбооны хөдөлмөрийн алба 2001 он

**Герман дахь ажилгүйчүүдийн тоо, ажлын сул байр,  
ажилгүйчүүдэд зуучилсан байдал 1997-2000 онд**

	1997 он	1998 он	1999 он	2000 он
Ажилгүйчүүд (саяар)	4,4	4,3	4,1	3,9
Ажлын сул байр (мянгаар)	337	422	456	514
Ажилгүйчүүдэд ердийн байдлаар ажлын байр зуучилсан нь	2475999	2847547	2927869	2738718
Ажлын байр бий болгох арга хэмжээний хүрээнд зуучилсан нь	215908	372981	321437	294939

Эх сурвалж: Холбооны хөдөлмөрийн алба 2001 он

**Холбооны хөдөлмөр зохицуулалтын албаны төсөв** 2000 онд 97,020 (1999 онд 93,790) млрд ДМ-ийн орлого /үүнээс 90,670 (88,288) млрд ДМ-ийг ажилгүйдлийн даатгалаас олсон орлого эзэлнэ/, 98,716 (101,104) млрд ДМ-ийн зарлага /үүнээс 46,179 (50,714) млрд ДМ-ийг ажилгүйдлийн тэтгэмж болгон олгосон)/ -аас бүрдсэн байна.

Хууль бус хөдөлмөр эрхлэлт ба нийгмийн халамжийн тэтгэмжийн мөнгийг завшсан байж болзошгүй сэжигтэй байдлын

үлгээгээр 2000 онд Холбооны Хөдөлмөр зохицуулалтын албанаас нийт 139.700 (1998 онд 372.300) хэргийг шалгаж, үүнээс 253.500 (266.200)-ийг шийдвэрлэсэн байна. Ноогдуулсан мөнгөн торгуулийн хэмжээ 309 сая ДМ-д хүрч, урьд жилийнхээс 66 саяар өсчээ. Үүнд эрх мэдлээ үрвүүлэн ашигласан хэрэгт оногдуулсан торгууль шийтгэл 0,1 саяар буурч 30,7 сая ДМ-д хүрсэн ба ажиллах эрхийн зөвшөөрлийн журмыг зөрчсөнөөс үүдсэн торгууль шийтгэл 6,1 сая ДМ-аар буурч 58,6 сая ДМ-д хүрсэн бол харин хөдөлмөр эрхлэгчдийг хууль бусаар ажилд авсан зөрчилд оногдуулсан торгууль шийтгэл 12,2 саяар өсч, 55,8 сая ДМ-д хүрчээ. Торгууль шийтгэлийн хамгийн их хэсэг нь буюу 133,7 сая ДМ (1999 онд 76,7 сая ДМ) нь ажиллах хүчнийг шилжүүлэх тухай хуулийг зөрчсөн тохиолдлуудад ноогдуулсан торгууль байлаа.

Холбооны Статистикийн Албаны мэдээгээр хувиараа ажил эрхлэлгүйгээр мэргэжлийн ажлаа эрхлээд дундаж цалин авдаг 4 ам бүлтэй өрхийн сарын дундаж орлого 1998 онд (1999 оны тоо баримт хараахан гараагүй байна) Баруун Германы муж улсуудад нийт 5571 (1997 онд 5476) ДМ, Зүүн Германы муж улсуудад нийт 4548 (1997 онд 4401) ДМ байв. Хадгаламжийн хүү, байрны түрээсийн мөнгө зэрэг бусад орлогыг оруулан тооцвол өрхийн сар тутмын нийт орлого Баруун Германд дунджаар 7240 (7052) ДМ, Зүүн Германд 5969 (5796) ДМ болно. Татвар болон нийгмийн даатгалын шимтгэл зэргийг хасвал өрхийн сар тутмын цэвэр орлогод Баруун Германд 5460 (5299) ДМ, Зүүн Германд 4540 (4422) ДМ үлдэж байна. Үүнээс хувийн хэрэглээнд Баруун Германд 4393 (4293) ДМ, Зүүн Германд 3632 (3556) ДМ зарцуулж байгаа бөгөөд үүнийг нарийвчлан авч үзье.

#### 4 ам бүлтэй өрхийн сар тутмын хувийн хэрэглээ (дунджаар)

Мөнгөн зарцуулалтын төрөл	Баруун Германд 1998 (1997) онд	Зүүн Германд 1998 (1997) онд
Байрны мөнгө, цахилгаан	1318 (1263)	896 (881)
Хоол хүнс ба архи тамхины зүйл	895 (903)	828 (833)
Зам тээвэр болон мэдээ, мэдээлэл дамжуулж авах (тухайлбал суудлын тэрэг, телефон утас)	756 (736)	693 (681)
Боловсрол, чөлөөт цаг, алжаалаа тайлах	505 (513)	408 (400)
Мебель, гэр ахуйн хэрэгсэл г. м.	301 (304)	330 (301)
Хувцас, гутал	274 (267)	218 (215)
Эрүүл мэнд, 4 арчилгаа сувилгаа	185 (152)	120 (105)

**Цэврээр үлдэх цалин хөлсний хэмжээ** 1999 онд Германд урьд жилийн төвшинг бараг л хадгалж байгаа бөгөөд зөвхөн 2 орчим (1,8) хувиар өссөн байна.

2000 онд үнийн өсөлт эрчимтэй явагдсан. *Хэрэглээний үнийн индекс* жилийн дундаж үзүүлэлтээр 1,9% (1999 онд 0,6%) байна. Урьд жилийн нэгэн адилаар үнийн өсөлт ерөнхийдөө эрчим хүчний үнэ өссөнөөс / +14,5%/ голчлон шалтгаалж байгаа бөгөөд харин энэ хугацаанд хүнсний бүтээгдэхүүн хямдарсан боловч үйлчилгээ, сүлжмэл нэхмэл бүтээгдэхүүн (+0,2%), байрны хөлс (+1,5), зам тээврийн үйлчилгээ (+2,5%) бага зэрэг өссөн байна. Эрчим хүчний өсөлтийг эс тооцвол үнийн дундаж өсөлт ердөө 0,8%-тай байна.

**Тэтгэвэрийнхэн:** Германд 2000 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар нийт 19.007.209 (1999 онд 18.545.802) тэтгэврийн хүмүүс байв. Үүнд 11.353.039 (11.141.061) эмэгтэй, 7.654.170 (7.404.741) эрэгтэй тэтгэвэр авч байна. Үүний дотор хэд хэдэн газраас тэтгэвэр авдаг эмэгтэйчүүд 3.280.358 (3.218.954), эрэгтэйчүүд 246.711 (225.931) байв.

Холбооны Статистикийн Албаны мэдээгээр 1999 онд (2000 оны тоо баримт хараахан гараагүй байна) **нийгмийн халамжийн тэтгэмжинд** зориулж 1306,555 (1998 онд 1272,058) млрд ДМ, / өөрөөр хэлбэл нэг хүн тутамд 15,902 (15,506) ДМ ноогдоно гэсэн үг/ олгосон байна. Нийгмийн халамжийн тэтгэмжийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 33,7% (1998 онд 33,5%) байв. 1999 онд нийгмийн халамжийн тэтгэмжийг доорхи хандив, эх үүсвэрүүдээс бүрдүүлсэн байна. Үүнд:

- ажил олгогчдын татвар – 437,620 (1998 онд 437,752) млрд ДМ
- олон нийтийн хөрөнгө - 457,215 (434,713) млрд ДМ
- даатгуулагчдын төлсөн мөнгө - 407,603 (404,1180) млрд ДМ

Нийгмийн халамжийн тэтгэмжийн 1999 оны зарцуулалтыг авч үзвэл:

### **1. Шууд тэтгэмж**

а. Ерөнхий систем:

- ø Ажилчдын тэтгэврийн даатгал – 213,526 (208,411) млрд ДМ
- ø Албан хаагчдын тэтгэврийн даатгал – 193,391 (190,253) млрд ДМ
- ø Гэнэтийн осолд орсон уурхайчдын тэтгэврийн даатгал - 28,020 (27,780) млрд ДМ

- а) Асрамжийн даатгал – 31,927 (30,696) млрд ДМ
- б) Эрүүл мэндийн албан ёсны даатгал – 255,267 (247,286) млрд ДМ
- в) Гэнэтийн ослын албан ёсны даатгал – 21,206 (21,248) млрд ДМ
- г) Ажил эрхлэлтийг дэмжих (Холбооны хөдөлмөр эрхлэлтийн албанаас олгосон тэтгэмж) - 135,952 (133,855) млрд ДМ
- д) Хүүхдийн тэтгэмжийн мөнгө - 0,187 (0,161) млрд ДМ
- е) Хүүхдийн хүмүүжилд зориулах мөнгө - 6,890 (7,156) млрд ДМ

б. Тусгай систем:

- а) Фермерүүдийн өндөр насны даатгал – 6,653 (6,825) млрд ДМ
- б) Төрийн албан хаагчдын ар гэрийнхний материаллаг баталгааг хангах – 3,520 (3,205) млрд ДМ

с. Төрийн байгууллагад зориулсан тэтгэмжийн систем:

- а) Тэтгэврийн мөнгө - 67,761 (63,836) млрд ДМ
- б) Гэр бүлийн нэмэгдэл – 14,314 (13,364) млрд ДМ
- в) Тусламж, тэтгэлэг – 16,793 (15,483) млрд ДМ

д. Ажил олгогчдод олгосон тэтгэмж:

- а) Цалинг тасралтгүй тавих – 48,465 (42,901) млрд ДМ
- б) Үйлдвэрийн өндөр настны тэтгэлэг – 27,510 (27,786) млрд ДМ
- в) Нэмэлт хангамж – 15,303 (14,647) млрд ДМ
- г) Ажил олгогчдод олгосон бусад тэтгэмж – 11,112 (4,260) млрд ДМ

е. Нөхөн олговор:

- а) Нийгмийн нөхөн олговор – 10,864 (11,362) млрд ДМ
- б) Дайны төлбөр хохирлыг барагдуулах – 0,314 (0,356) млрд ДМ
- в) Нацист дэглэмийн улмаас хохирогсдод нөхөн олговор төлөх – 2,814 (4,003) млрд ДМ
- г) Бусад нөхөн олговор – 0,276 (0,312) млрд ДМ

ф. Нийгэмд үзүүлэх тусламж, үйлчилгээ:

- а) Нийгмийн тусламж – 50,233 (50,137) млрд ДМ
- б) Залуучуудад үзүүлэх тусламж – 32,851 (30,940) млрд ДМ
- в) Боловсролыг дэмжих – 1,725 (1,646) млрд ДМ
- г) Байрны мөнгө төлөхөд туслах - 7,630 (7,556) млрд ДМ
- д) Хөрөнгө бий болгоход дэмжих – 2,138 (1,333) млрд ДМ

2. Шууд бус тэтгэмж:

- а) Татварын арга хэмжээгээр олгох тэтгэмж (Хүүхдийн мөнгө болон бусад хүүхдийн асрамжинд зориулагдсан хөнгөлөлтүүдийг оролцуулалгүйгээр) - 72,156 (74,335)

Ø Хүүхдийн мөнгө болон бусад хүүхдийн асрамжинд зориулагдсан хөнгөлөлтүүд – 57,700 (49,800) млрд ДМ

Холбооны Статистикийн Албаны мэдээгээр 1999 онд 39,0 млрд ДМ-ийг цэврээр **нийгмийн тусламжинд** зарцуулсан нь урьд онохоос 0,6%-иар илүү юм. Үүнээс 34,7 млрд ДМ (-0,4%) нь баруун Германы муж улсуудад, 5,2 млрд ДМ (+7,6%) нь зүүн Германы муж улсууд болон зүүн Берлинд зарцуулагдсан юм. Нийгмийн тусламж болгон зарцуулсан мөнгөнөөс 17,3 млрд ДМ нь (-4,7%) амин зуулгал залгуулахад тусламж хэлбэрээр очжээ. Харин амьдралын онцгой байдалд буй хүмүүст тусламж болгон 22,6 млрд ДМ (+5,1%)-ийг олгосон. Тухайлбал үүнд тахир дутуу хүмүүсийг нийгмийн амьдралд эргэж татан оруулахад 15,2 млрд ДМ (+7,6%) зарцуулсан бол асарган сувилгаа шаардлагатай хүмүүст 4,5 млрд ДМ (+1,6%)-ийн тэтгэмжийг олгожээ.

2001 оны 1 дүгээр сарын байдлаар **Эрүүл мэндийн албан ёсны даатгалын байгууллага** баруун Германд 41.210.122 (1999 оны 1 дүгээр сард 41.187.162), зүүн Германд 9.785.204 (9.913.374) гишүүнтэй байсан бөгөөд үүнээс:

- даатгалд зайлшгүй хамрагдах ёстой гишүүний тоо баруун Германд 23.463.225 (23.640.084), зүүн Германд 5.660.743 (5.826.970),
- баруун Германд 11.860.006 (11.847.837), зүүн Германд 3.462.988 (3.435.116) тэтгэврийн хүмүүс,
- баруун Германд 5.886.891 (5.699.241), зүүн Германд 661.473 (651.288) сайн дураараа даатгуулагч байна.

### Нийтийн санхүү

Холбооны Статистикийн Албаны мэдээгээр улсын төсвийн тэнцэл (нийтийн төсвүүдийг оролцуулаад) 2000 онд /хэсэгчилж дүгнэсэн/ -34,0 (1999 онд -47,0) млрд ДМ-ийн санхүүгийн алдагдалтай гарсан байна. Төсвийн зарлага 2000 онд 1873,5 (1999 онд 1856,0) млрд ДМ болсон бөгөөд төсвийн зарцуулалтыг авч үзвэл:

- нийгмийн даатгалын шимтгэл – 849,0 (831,0) млрд ДМ
- зээлийн хүүнд төлсөн төлбөр – 132,5 (136,5) млрд ДМ
- боловсон хүчний зардал – 330,5 (330,0) млрд ДМ гэх мэт.

70-аад оны дунд үеэс хойш **Холбооны төсөв** ихээхэн алдагдалтай болж, улмаар шаардагдах зээлийг авдаг болжээ. Энэ

байдал хоёр Герман нэгдсэнээс хойш цаашид улам хурцатсан. 1999 оноос хойш цэвэр зээл авах явдлыг багасгах арга хэмжээг авах болсон. Энэ арга хэмжээний дүнд 2004 он гэхэд цэвэр зээл авах явдлыг 51,1 млрд ДМ-аас 20,0 млрд ДМ хүртэл алхам алхмаар бууруулах ажээ. 247,8 (243,9) млрд еврогийн төсвийг санхүүжүүлэхийн тулд 2002 онд 22,1 (22,3) млрд еврогийн цэвэр зээл алхаар 2001 оны төсвийн төлөвлөгөөнд тусгажээ.

**Холбооны Бундесбанк 2000 оны нийтийн төсвийн өрийн хэмжээг /2000 оны эцэс гэхэд төсвүүд өөр хоорондоо өргүй байх/ 1211,4 (1999 онд 1200,0) млрд евро байх бөгөөд мөн доорхи байдалтайгаар хуваарилагдана гэж тооцжээ. Үүнд:**

- Холбоо 715,8 (714,1) млрд евро
- Баруун Германы муж улсууд – 282,4 (274,2) млрд евро
- Зүүн Германы муж улсууд - 55,7 (53,2) млрд евро
- Баруун Германы хороод – 81,4 (81,5) млрд евро
- Зүүн Германы хороод – 17,0 (20,7) млрд евро
- „Германы нэгдэл”/Нөхөн олговрын фонд – 40,6 (40,2) млрд евро
- ERP- Тусгай хөрөнгө - 18,4 (16,0) млрд евро

2000 оны эцсийн байдлаар нийтийн төсөвт зээлийн институтууд 665,4 (1999 онд 596,0) млрд евро; гадаадын зээлдүүлэгч нар 431,1 (412,2) млрд евро; Холбооны Бундесбанк 4,4 (4,4) млрд евро; нийгмийн даатгалаас 0,2 (0,3) млрд еврог тус тус зээлдүүлсэн байна.

### 1999-2001 оны Холбооны төсөв

/2001 оны төслийн төлөвлөгөөнөөс эхлэн еврогоор тооцох болсон/

	Нарийвчилсан төлөвлөгөө*	1999 гүйцэтгэл сая ДМ	2000 оны төлөвлөгөө сая ДМ	2000 оны гүйцэтгэл сая ДМ	2001 оны төлөвлөгөө сая ДМ	2001 оны төлөвлөгөө сая евро
01	Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газар	37	36	38	36	18
02	Бундестаг	1 037	1 100	998	1 106	566
03	Бундесрат	24	47	32	35	18
04	Холбооны Канцлерийн ажлын алба	2 878	2 817	2 770	2 857	1 461
05	Гадаад Хэргийн Яам	3 592	3 469	3 844	4 141	2 117

06	Дотоод Явдлын Яам	7 082	7 062	6 965	7 084	3 622
07	Хууль зүйн Яам	719	694	697	680	348
08	Сангийн Яам	7 143	7 392	6 694	6 972	3 565
09	Эдийн засаг, технологи	16 913	14 929	16 067	14 294	7 309
10	Хэрэглэгчдийг хамгаалах, хүнс тэжээл, хөдөө аж ахуй	11 514	11 016	11 115	10 959	5 603
11	Хөдөлмөр, нийгмийн халамж	170 646	170 458	167 090	169 649	86 740
12	Зам тээвэр, барилга, байр сууц	51 742	49 724	50 704	48 574	24 835
14	Батлан хамгаалах	48 067	45 333	45 565	46 862	23 960
15	Эрүүл мэнд	1 617	1 837	1 841	1 774	907
16	Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал, цөмийн цахилгаан станцын аюулгүй байдал	1 026	1 088	932	1 140	583
17	Гэр бүл, ахмадууд, эмэгтэйчүүд, залуучууд	11 507	10 966	10 494	10 762	5 503
19	Холбооны Үндсэн Хуулийн цэц	26	27	27	30	15
20	Холбооны хянан шалгах газар	119	168	138	161	82
23	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжил	7 798	7 103	7 166	7 427	3 797
30	Боловсрол, судалгаа	14 675	14 592	14 481	15 974	8 168
32	Холбооны өр	83 309	83 768	81 456	81 854	41 851
33	Хангамж	16 320	17 007	16 369	17 396	8 895
60	Санхүүгийн ерөнхий захиргаа	25 042	28 169	32 533	27 231	13 923
	<b>Нийт ДМ-ээр</b>	<b>482 834</b>	<b>478 800</b>	<b>478 014</b>	<b>477 000</b>	
	<b>еврогоор</b>					<b>243 886</b>

\* дугуйлсан тоонууд

Эх сурвалж: Холбооны сангийн яам, 2001 оны 8 дугаар сар.

**2002 оны Холбооны төсөв**

	Нарийвчилсан төлөвлөгөө*	2002 оны төсөл  сая евро	Өөрчлөлт %-иар		
			2000/99 <sup>1</sup>	2001/00 <sup>2</sup>	2002/01 <sup>3</sup>
01	Холбооны Ерөнхийлөгчийн Тамгын газар	21	1,6	- 6,1	12,6
02	Бундестаг	568	- 3,8	10,9	0,4
03	Бундесрат	18	33,5	10,3	0,5
04	Холбооны Канцлерийн ажлын алба	1 485	- 3,7	3,2	1,6
05	Гадаад Хэргийн Яам	2 104	7,0	7,7	- 0,6
06	Дотоод Явдлын Яам	3 630	- 1,6	1,7	0,2
07	Хууль зүйн Яам	343	- 3,0	- 2,4	- 1,4
08	Сангийн Яам	3 431	- 6,3	4,2	- 3,8
09	Эдийн засаг, технологи	6 375	- 5,0	- 11,0	- 12,8
10	Хэрэглэгчдийг хамгаалах, хүнс тэжээл, хөдөө аж ахуй	5 659	- 3,5	- 1,4	1,0
11	Хөдөлмөр, нийгмийн халамж	88 878	- 2,1	1,5	2,5
12	Зам тээвэр, барилга, байр сууц	26 338	- 2,0	- 4,2	6,0
14	Батлан хамгаалах	23 622	- 5,2	2,8	- 1,4
15	Эрүүл мэнд	1 389	13,8	- 3,6	53,1
16	Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал, цөмийн цахилгаан станцын аюулгүй байдал	543	- 9,2	22,4	- 6,9
17	Гэр бүл, ахмадууд, эмэгтэйчүүд, залуучууд	5 424	- 8,8	2,6	- 1,4
19	Холбооны Үндсэн Хуулийн цэц	16	5,1	8,0	5,6

20	Холбооны хянан шалгах газар	80	16,2	16,2	- 2,7
23	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжил	3 595	- 8,1	3,6	- 5,3
30	Боловсрол, судалгаа	8 391	- 1,3	10,3	2,7
32	Холбооны өр	42 287	- 2,2	0,5	1,0
33	Хангамж	9 000	0,3	6,3	1,2
60	Санхүүгийн ерөнхий захиргаа	14 602	29,9	- 16,3	4,9
	<b>Нийт ДМ-ээр еврогоор</b>	<b>247800</b>	<b>- 1,0</b>	<b>- 0,2</b>	<b>1,6</b>


<sup>1</sup>2000 ба 1999 оны төсвийн гүйцэтгэлийг харьцуулсан нь

<sup>2</sup>2000 оны төсвийн гүйцэтгэлийг 2001 оны төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан нь

<sup>3</sup>2001 оны төсвийн төлөвлөгөөг 2002 оны төсвийн төсөлтэй харьцуулсан нь

Эх сурвалж: Холбооны сангийн яам, 2001 оны 8 дугаар сар.

**Холбооны муж улсуудад ажилгүйчүүдийн  
эзлэх хувь 2001 оны 6 дугаар сарын байдлаар  
(%-иар)**



Эх сурвалж: Холбооны Хөдөлмөр Зохицуулалтын Алба

**Үйл явдлын хураангуй:** Холбооны Канцлер Герхард Шредерийн тэргүүлсэн ГСДН, Ногоонтны намын эвслийн засгийн газар өнгөрөгч хугацаанд хэдийгээр сөрөг хүчний хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч, ихээхэн хасагдаж танагдсан ч хэд хэдэн хуулийн төсөл (Тэтгэврийн шинэчлэл, Нацизмын үед албадлагын хөдөлмөр эрхэлж байсан ажилчдад нөхөн төлбөр олгох, Ижил хүйстэний харьцааг

хүлээн зөвшөөрөх, Муж улсуудын хоорондын татаасыг шинээр зохицуулах), шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

2001 оны 8 дугаар сард Дотоод Явдлын Яамны сайд Отто Шили цагаачлалын асуудлаар зөвшилцөлд хүрч болохуйц хуулийн төслийг дэвшүүлэн гаргасан нь 2002 оны Бундестагийн сонгуулийн өмнө гадаад иргэдийн талаар баримтлах бодлого хэт зөрүүтэй байхаас сэргийлсэн хэрэг байлаа.

ХАХ, ХНХ-ны лидер улс төрчид „Удирдах соёл”, „Үндэсний бахархал” зэрэг сэдвийг дэвшүүлэн хөндөж, улс төрийн дотоод уур амьсгалыг ХАХ намын хандивийн будлиантай хэргээс холдуулах оролдлого хийсэн нь 2000/2001 оны намар, өвөл нэлээд бүтэмжтэй байсан боловч төдөлгүй Ангела Меркелээр удирдуулсан ХАХ намын дотоод удирдлагад гарсан хагарал болон ХАХ/ХНХ-оос Канцлерт дэвшүүлэх нэр дэвшигч тодорхойгүй байсан зэрэг асуудлууд хүмүүсийн анхаарлыг илүүтэй татах болжээ.

Берлинд Их эвсэл 6 дугаар сард тарж, Парламентаас сонгуулийн товыг тогтоосны дараагаар ГСДН шаардлагатай нөхцөлд посткоммунист Ардчилсан Социализмын Намтай эвсэл байгуулах боломжтой эсэх талаар маргаж эхэлсэн.

Германы эдийн засгийн байдал тооцоолж байснаас илүү уналтанд орж шахалт дарамт нэмэгдсэн бөгөөд ойрын хугацаанд ажилгүйчүүдийн тоо буурах хандлага ажиглагдахгүй байгаа хэдий ч Шредер өөрийн Засгийн газрын нийгмийн баримжаат бодлогын ач холбогдол, нааштай үр дүнг үнэлж байлаа. Мөн Шредерийн намын дотроос болон сөрөг хүчний зүгээс түүнийг тогтворжуулалтын бодлого явуулахаас татгалзаж эдийн засгийн байдлыг сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг шаардсан боловч Шредер уг шаардлагыг хүлээн авалгүй харин цаашид ч „аядуу бодлого”-оо тууштай баримтална гэж 7 дугаар сард мэдэгдсэн.

**Холбооны засгийн газар:** 11 дүгээр сараас 1 дүгээр сарын хооронд холбооны гурван сайд, нэг төрийн сайд огцорсноор Холбооны засгийн газрын боловсон хүчний тогтвортой байдлыг эрхэмлэх гэсэн Холбооны Канцлерын эрмэлзэл бүтээгүй юм.

Барилга, зам тээврийн сайд Райнхард Климмт /Reinhard Klimmt/ (ГСДН) нь “1.ФЦ Заарбрюкэн” хөл бөмбөгийн холбоо (Fußballverein 1.FC Saarbrücken)-г 1990-ээд оны дунд үед хууль бусаар спорсорлосны улмаас 11 дүгээр сарын 13-нд ял шийтгэл хүлээх нь

тодорхой болсон тул тэрээр 11 дүгээр сарын 16-нд албан тушаалаа өгөхөөс аргагүй болсон. Тухайн үед Парламентын төрийн нарийн бичгийн дарга асан Курт Бодевиг /Kurt Bodewig/ 11 дүгээр сарын 20-нд түүний ажлыг хүлээн авсан.

Михаел Науманн /Michael Naumann/ (ГСДН) долоо хоног тутмын "Die Zeit" сонины эрхлэгчээр ажиллах болсон тул философийн ухааны профессор, Мюнхений соёлын референт Юлиан Нида Рюмелин /Julian Nida Rümelin/ (ГСДН)-ийг Холбооны Канцлерийн ажлын албаны соёл, мэдээллийн хэрэгслийг хариуцсан төрийн сайдын албанд 2001 оны 1 дүгээр сарын 10-нд томилсон.

Үхрийн галзуу өвчин (BSE) дэлгэрсний улмаас 1 дүгээр сарын 9-нд Эрүүл мэндийн сайд хатагтай Андреа Фишер /Andrea Fischer/ (Холбоо 90/Ногоонтны нам), Хөдөө аж ахуйн сайд Карл Хайнц Функе /Karl Heinz Funke/ (ГСДН) нар огцорсон. Дараачийн өдөр нь Улла Шмидт /Ulla Schmidt/ (ГСДН), Ренате Кюнаст /Renate Künast/ (Холбоо 90/Ногоонтны нам) нарыг Шрёдер тэдний оронд томилсон. Ренате Кюнаст яамны бүтцийг шинэчилж, газар тариалангийн бодлогод шинэ чиглэлийг гаргаж ирсэн.

2001 оны 1 дүгээр сард Гадаад хэргийн сайд Йошка Фишер (Холбоо 90/Ногоонтны нам) дарамтанд орсон. Энэ нь Йошка Фишер 1973 онд Франкфурт/Майнд нэгэн цагдаагийн эсрэг хүч хэрэглэхэд бэлэн байгааг харуулсан гэрэл зургийн хальсыг сурвалжлагч Беттина Рөэл /Bettina Röhl/ нийтлүүлснээс үүдсэн ажээ. Беттина Рөэл бол Штуттгарт-Штаммхаймын шоронд 1976 онд амиа хорлон нас барсан, Улаан армийн фракцийн (RAF-die Rote Armee Fraktion) удирдагч асан Уприке Майнхоф /Ulrike Meinhof/-ын охин юм. "68 оны үеийнхэн"-ий "улс төрийн өв"-ийг хэлэлцэх үед Фишер хүч хэрэглэхэд бэлэн байснаасаа сургамж авч засарсан бөгөөд энэ нь түүний намтар дахь "өнгөрсөн зурвас үе" болсон гэжээ. ХАХ/ХНХ-ны сөрөг хүчин дээрх хэлэлцүүлгийн үед Фишерийн өнгөрсөн амьдрал Гадаад хэргийн яамны сайдын албыг хашихад нь харшилж байна гэж үзжээ.

**Герман нэгдсэний арван жилийн ойд:** Герман нэгдсэний арван жилийн ойг тохиолдуулан Канцлерийн ажлын албан дахь Зүүн Германы бүтээн байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн сайд Рольф Шванитц /Rolf Schwanitz/ (ГСДН) тайлангаа Холбооны Засгийн газарт танилцуулсан бөгөөд тэрээр нэгдлийн процесст зүүн германчуудын оруулсан хувь нэмрийг онцлон тэмдэглэж, Зүүн Германы эдийн

засгийн хөгжилд “дэвшил” гарсныг сайшаасан. Гэвч Зүүн Германд эдийн засгийн дэмжлэгийг харамгүй үзүүлсээр атал Зүүн Германы муж улсууд “өнөөг хүртэл өөрөө өөрийнхөө хүчээр эдийн засгийн өсөлт хийх хэмжээнд хараахан хүрээгүй байна” гэжээ.

Баруун, Зүүн Германы амьжиргааны төвшин богино хугацааны дотор ижил хэмжээнд хүрээгүйд Зүүн Германы муж улсуудын оршин суугчид гонсгор байна. Иймээс “Дотоод нэгдлийн” процесст ахиц дэвшил гарч байна гэж өөдрөгөөр үзэхгүй байхыг Зүүн Германы улс төрчид сануулж байв.

Бундестагийн ерөнхийлөгч Вольфганг Тийрзе /Wolfgang Thierse/ (ГСДН) 2001 оны 1 дүгээр сарын 3-нд нийтлүүлсэн тайландаа Зүүн Германд эдийн засаг, нийгмийн байдал, тогтворгүй байгаа бөгөөд иргэдийн итгэл үнэмшил улам алдагдаж, тусгаарлагдмал нийгэм бий болгохгүйн тулд тэнд эдийн засгийн бие даасан үндсийг бүрдүүлэхэд зайлшгүй шаардагдах нөхцлүүдийг бий болгохыг шаардсан байна.

Муж улсуудын санхүүг тэнцвэржүүлэх ажлын хүрээнд Зүүн Германд тусламжийн нэгэн шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 6 дугаар сард холбоо, муж улсууд санал нэгдсэн.

### **Үхрийн галзуу өвчин BSE ба шүлхий өвчин**

**Үхрийн галзуу өвчин BSE** – Их Британид үхрийн галзуу өвчин BSE дэгдсэнээс хойш таван жилийн дараа буюу 2000 оны 11 дүгээр сарын 24-нд ХБНГУ-ын Шлесвиг-Хольштайн муж улсад BSE-г илрүүлэх богино хугацааны сорил хийснээр Германд энэ тахал өвчний анхны тохиолдлыг илрүүлжээ. 2000 оны 12 дугаар 1-нд Бундестаг, Бундесратаас яаралтай хууль (уг хуулинд ясны гурил хийхийг хориглосон) гаргасны дагуу 30 сартайгаас дээшхи насны нядалгаанд орсон үхрийн маханд Герман даяар хийсэн BSE-ийн сорилын дараа Германд BSE илэрсэн тохиолдол 2001 оны 8 дугаар сарын эхээр 94 болтлоо өсчээ.

BSE тахлыг үүсгэгч вирус нь хүнд халдаж Creutzfeldt-Jacob гэгч өвчний нэг хэлбэрийг үүсгэх боломжтой гэсэн сүүлийн үеийн судалгааны дүн Германы хүн амын дотор болгоомжлол төрүүлсний учир Германд мөн оны өвөл, хавар үхрийн махны хэрэглээ урьд жил буюу 1999/2000 онтой харьцуулахад 50 гаруй хувиар буурч, үхрийн махны үнэ 1/3-ээр буурчээ.

Хэрэглэгчдийн итгэлийг дахин сэргээж, үхрийн махны зах зээлийг тогтворжуулахын тулд ясны гурил хийхийг хориглох, BSE-ийн сорилыг хэрэглэх, үхрийг олноор нь нядлах, махыг интервенцээр

худалдаж авах /махны үнийг зохицуулах замаар/, үйл ажиллагааны хөтөлбөрийг санхүүжүүлэх талаар зохих яаралтай шийдвэрүүдийг Европын Холбооны хэмжээнд гаргуулахыг Холбооны Засгийн газар чармайж байлаа.

Эрүүл мэндийн сайд Фишер, газар тариалангийн сайд Функе нарыг огцруулсны дараа Шрёдер хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх шинэ чиглэлийг газар тариалангийн бодлогод баримтлах болсноо мэдэгдсэн. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хүнс тэжээл, хөдөө аж ахуйн хэмээн нэрээ өөрчилсөн уг яамны сайд Ренате Кюнаст мэдэгдэлдээ “бүхний нүдэнд ил, мапаангүй бүтээгдэхүүн” гаргах, мужийн бүтцийг бэхжүүлэх, мал маллагааг өөрчлөх талаар дурдсан байна. Европын Холбоо газар тариалангийн салбарт татаас олгох бодлого хэрэгжүүлэхдээ үндэсний улсуудад илүү чөлөөтэй ажиллах боломж олгохыг тэрээр шаардсан. Ийм боломж олгосноор байгаль орчин болон хэрэглэгчдэд ээлтэй ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дөхөмтэй болно гэжээ.

Газар тариалангийн бодлогод хийх шинэчлэлийг санхүүжүүлэх тухайд Холбооны сангийн сайд Ханс Айхел хэлэхдээ шаардагдах 600 сая ДМ-ийн оронд харин 2002 оны 6 дугаар сард төсвийн төлөвлөгөө хэлэлцэх үеэр ирэх 2 жилийн хугацаанд тэдний төсвийг 330 сая ДМ-аар нэмэгдүүлэхийг зөвшөөрч буйгаа илэрхийлжээ.

**Шүлхий өвчин** – Шүлхий өвчин 2001 оны 2 дугаар сард Их Британид дэгдэж, Франц, Нидерландад тархсан ч Европын Холбоотой хамтран урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимтэй авсны ачаар уг өвчин Германд гараагүй бөгөөд иймд 2001 оны 5 дугаар сарын 20-нд Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах яамны гамшгийн штаб тахлыг аюул өнгөрснийг мэдэгджээ.

### **Нийгмийн бодлого**

**Тэтгэврийн шинэчлэл:** Тэтгэврийн даатгалын татварын хэмжээ (2001 онд нийт цалингийн 19,1%-ийг эзэлж байв)-г удаан хугацааны туршид тогтвортой байлгах, татвар төлөгч ба тэтгэвэр авагчдын хооронд шударга харьцааг бататгах зорилгоор эвслийн Засгийн газар тэтгэврийн системийг үе шаттайгаар шинэчилсэн. Сөрөг хүчнийг шинэчлэлийн хөтөлбөрт татан оролцуулах гэсэн эвслийн Засгийн газрын чармайлт бүтэлгүйтсэнээс гадна тэдний дэвшүүлэн тавьсан анхны концепци ихээхэн өөрчлөгдөхөд хүрсэн явдалтай эвслийн Засгийн газар эвлэрэхээс аргагүй болсон.

2000 оны 11 дүгээр сарын 17-нд Бундестаг тахир дутуугийн тэтгэврийн оронд мэргэжлийн чадвар буурсны тэтгэврийг олгохоор шийдвэрлэсэн. Тахир дутуу иргэн хэр зэрэг ажлын чадвартай үлдсэн, хагас цагаар ажиллах байнгын ажлын байр олох боломж хэр их байгаа зэргийг харгалзан үзсэний эцэст тэтгэвэр авагсдын тоог (1999 онд 1,9 сая хүн) цөөрүүлж, тэтгэврийн хэмжээг багасгасан бөгөөд тэтгэвэрт гарах насны хязгаарыг 60 байсныг алхам алхмаар нэмэгдүүлж 63 болгосон. (2001 оны 1 дүгээр сарын 1-нээс үйлчилж эхэлсэн). 40-өөс дээш насны тахир дутуу хүнд мэргэжлийн чадвараа алдсаны тэтгэвэр олгодог байсныг болиулсан.

5 дугаар сарын 11-нд Бундесрат, Бундестаг нь тэтгэврийн шинэчлэлийн хоёрдахь хэсгийг баталсан. Уг тэтгэврийн шинэчлэлийн гол цөм нь нэмэлт тэтгэмж олгох тухай (Настай хүмүүсийн өмчийн тухай хууль, 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс үйлчилж эхэлсэн) хэсэг юм. Энэ нь тэтгэврийн даатгалыг хүн бүр тус тусдаа төлдөг одоогийн арга барилыг бататгаж, ядуувар тэтгэвэр авагчдад үндсэн баталгааг олгохын (2003 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчинтэй) хамт тэтгэврийн ангилалд өөрчлөлт (2001 оны 7 дугаар сарын 1 ба 2011 оноос хүчинтэй) оруулж байна. Настай хүмүүсийн өмчийн тухай хуулийн дагуу төр нь татварын хөнгөлөлт үзүүлэх, шууд татаас олгох замаар настай хүмүүст зориулсан халамжийн хувийн системийг үе шаттайгаар бий болгоход дэмжлэг үзүүлэх бөгөөд хамгийн сүүлчийн үе шат эхлэх 2008 оноос жил тутам 20,8 млрд ДМ-ыг татварын хөнгөлөлт, шууд татаас олгоход зориулна. Эрүүл мэндийн албан ёсны даатгалын татвараа төлж, хадгаламж, даатгалын санг бүрдүүлээд, уг сангаас 60 нас буюу тэтгэвэр авах үеэс эхлэн бүхий л амьдралынхаа туршид сар бүр тэтгэвэр авах хэн бүхэнд дэмжлэг үзүүлнэ. Үзүүлэх гол дэмжлэг нь жил тутмын үндсэн нэмэлт (2002-2008 оны хооронд 38-аас 154 евро хүртэл нэмэгдэнэ) ба хүүхдийн нэмэгдэл (46-аас 154 евро хүртэл өснө)-ээс бүрдэнэ. Эдгээр дэмжлэгийг үзүүлэхийн оронд эс бөгөөс тусгай зардалд оноох татвараас чөлөөлөх боломжтой юм. Хэрвээ тухайн хүний цалин хөлс, дэмжлэгийн хамтаар орлогын хамгийн багад тооцогдох тодорхой хувьд байх (2002 онд 1% байсныг 2008 оноос 4% хүртэл нэмэгдүүлнэ) аваас тухайн заагдсан хамгийн өндөр хувийг авч ашиглах эрхтэй. Дээрхи өөрчлөлтийн дүнд тэтгэврийн ердийн хэмжээ (дундаж цалин авч, 45 жилийн туршид татвар төлсөн этгээдийн авах тэтгэврийг ердийн гэж үзсэн) орлогын 70% байсныг 2030 хүртэл 64% болтол

бууруулах боловч төрийн дэмжлэгтэйгээр настайчуудыг халамжлах замаар 76% хүртэл нэмэгдүүлэх ажээ. Тэтгэврийн даатгалд төлөх татварын хэмжээг 2020 он хүртэл 20%-иас доош, 2030 он хүртэл 22%-иас доош барих ажээ.

Тэтгэврийн шинэчлэлийн өөр нэгэн чухал хэсэг болох бэлэвсрэн үлдэгсдийн эрхийн шинэчлэлийг 2002 оны 6 дугаар сарын 1-нд Бундестаг хүлээн зөвшөөрсөн. 2002 оны 1 дүгээр сарын 1-нд уг хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэх үед 40 нас хүрээгүй бэлэвсэн хүмүүс ба үүнээс хойш гэр бүл бологсдоос бэлэвсрэн үлдэгсдийн авах тэтгэмжийн хэмжээг 60-иас 55% болгож бууруулсан. Тэд энэ тэтгэмжээс гадна мөн хүүхдийн нэмэгдэл мөнгө, капитал г.м-ээс олох орлогыг авна. Бэлэвсэрсний тэтгэмжийн оронд тэтгэврийг хуваан олгох нэгэн шинэ тэтгэмжийг авч болох бөгөөд үүнийг гэр бүл бологсод тэтгэвэрт гарсан хойно авах байсан тэтгэврийн тал хувиар бодож олгоно.

**Шатлалын дагуу хөнгөлөлт эдлүүлэх** - Эрчим хүчний үнэ ихээхэн нэмэгдсэн учир хариу арга хэмжээ болгон ажлын байр хүртэл унаагаар явах буюу ирэхэд үзүүлэх татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлэхээр 12 дугаар сарын 7-нд Бундестаг шийдвэрлэсэн бөгөөд хөнгөлөлтийг километр тус бүрээр нэг бүрчлэн тооцдог байсныг өөрчилж харин тодорхой шатлалтайгаар тооцохоор 1998 онд эвслийн гэрээнд тусгасныг хэрэгжүүлсэн. Татварын мэдэгдлийн хуудсан дээр гэврийн ямар хэрэгслээр явснаас үл хамааран 70 пфенниг, 11 дэх км-ээс эхлээд техник зардлыг харгалзан үзээд 80 пфенниг байхаар тогтжээ. (2001 оны 1 дүгээр сарын 1-нээс үйлчилж эхэлсэн)

**Гэр бүлд хөнгөлөлт үзүүлэх** – Гэр бүлд 4,6 млрд ДМ-ийн хөнгөлөлтийг авчрах багц арга хэмжээг 7 дугаар сарын 7 дугаар Бундестаг, 7 дугаар сарын 13-нд Бундесрат баталсан (2002 ны 1 дүгээр сарын 1-нээс үйлчилж эхэлсэн). Анхны болон хоёрдахь хүүхдэд зориулсан хүүхдийн мөнгө 30 ДМ-ээр нэмэгдэж 300 ДМ болсон. Ерөнхий асаргаа сувилгаанд зориулан гаргасан төлбөрийг татвараас чөлөөлдөг байсны үндсэн дээр хүүхдийн хүмүүжилд зориулж орлогын тодорхой хэсгийг татвараас чөлөөлөх журмыг шинээр гаргаж, түүнийг 1188 ДМ нэмэгдэлтэйгээр нийт 4225 ДМ байхаар тогтоосон. Өрх толгойлсон ганц бие хүмүүс болон эхнэр нөхөр хоёр хоёулаа ажил хийдэг гэр бүлийн хувьд 14 хүртэлхи насны хүүхдүүдээ асрахад зориулж 2934 хүртэлхи ДМ-г татвараас чөлөөлөх болжээ. Харин авсан сөрөг арга хэмжээ гэвэл ганц бие өрх толгойлсон хүмүүсийн хувьд өрхийн орлогын татвараас чөлөөлөгдөх хувийг 2005 он гэхэд алхам

алхмаар багасгаж улмаар хүчингүй болгох бөгөөд боловсролд зориулан гаргасан төлбөрт татвар төлөхгүй байх эрхтэй хүмүүсийн тоо, хүрээг ихээхэн хязгаарласны зэрэгцээ гэрийн үйлчлэгчид төлөх цалингийн төлбөрийг татвараас чөлөөлдөг байсныг хүчингүй болгосон.

**Холбооны боловсролыг дэмжих хууль** – Бундестаг 2001 оны 2 дугаар сарын 15-нд ХАХ/ХНХ, АСН мөн эвслийн намын зөвшөөрсөн саналыг авч, харин ЧАН-ын түтгэлзсэн саналтайгаар Холбооны боловсролыг дэмжих хуулийн нэмэлт өөрчлөлтийг батлан гаргасан бөгөөд энэ нь бололцоо тааруу оюутан, суралцагчдад үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх ажээ. (4 дүгээр сарын 1-нээс хүчинтэй болсон) Сар тутамд үзүүлэх дэмжлэгийн хамгийн дээд хэмжээ 1030 байсныг 1140 ДМ, дундаж хэмжээ 640 байсныг 750 ДМ болгож нэмэгдүүлсэн. Холбооны боловсролыг дэмжих хуулинд шинээр тусгасан бас нэгэн зүйл бол сургалтын тусгай зардалд зориулж боловсролын зээл олгох болсон явдал юм. (2 жил хүртэлхи хугацаанд сар бүр 300 евро). Мэргэжлийн боловсролоо дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай хуулийг 7 дугаар сарын 18-нд шинэчлэн гаргасан. (2002 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчинтэй болсон)

### **Эдийн засаг, санхүүгийн бодлого**

**Муж улсуудын санхүүг тэнцвэржүүлэх** - Муж улсуудын хооронд татаасыг шинээр зохицуулах мөн зүүн Германд “Эв нэгдлийн холбоо II” (Solidarpakt II) хэмээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар муж улсуудын ерөнхий сайд нар Холбооны сангийн сайдтай санал нэгдсэн. Үүний дараахан буюу 6 дугаар сарын 24-нд Бундестаг (7 дугаар сарын 5-нд), Бундесрат (7 дугаар сарын 13-нд) нь холбоо, муж улсуудын хооронд санхүүгийн тэнцвэртэй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн суурь хуулийг баталсан. Холбооны улсын хэмжээнд амьжиргааны төвшинг ижил хэмжээнд авчрахын тулд нэмэгдэл өртгийн татвараас олсон орлогыг холбоо ба муж улсуудад хуваарилах шинэ зарчмыг дээрхи хууль тодорхойлох бөгөөд үүнийг 1999 оноос 2003 оны 1 дүгээр сарын 1 хүртэлхи хугацаанд хийх үүрэг даалгаврыг Холбооны Үндсэн Хуулийн Цэц хууль тогтоох байгууллагад өгсөн. Энэ нь муж улсуудын хоорондын татаасыг зохицуулах тухай хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөх боломжтой болгохын тулд хийж буй нэгэн алхам юм.

2000 онд 64,4 млрд ДМ-ын зардал гаргаж санхүүг тэнцвэржүүлэх арга хэмжээг авсан бөгөөд Дээд Шүүхийн дүгнэлтээс авч үзэхэд энэ нь баян муж улсуудад татвараасаа (12%) илүүчилж,

хадгалах шинэ таатай бүтцийг бүрдүүлж байна. Үүнээс гадна тэдгээр баян муж улсууд нэмэгдэл өртгийн татварын орлогоосоо дээд тал нь 72,5% (одоог хүртэл 80%) тэнцвэржүүлэх системд оруулах ёстой. Хариуд нь муж улсуудын санхүүгийн чадавхийг тодорхойлохдоо хороодын санхүүгийн чадавхийг 50%-д биш, харин 64 %-д хүрэхүйц байхаар тогтоох болжээ. Ялангуяа үүнд хот улсууд онцгой их ачаалалтай байдгийг харгалзан үзсэн. "Германы Нэгдэл" фондын санхүүжилтээр холбооны улс жил тутам 2,5 млрд ДМ-г тэнцвэржүүлэх системд оруулах ажээ. Зүүн Германы муж улсууд "Эв нэгдлийн холбоо" (Solidarpakt) хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн гатаас авах хүртэл 1990-94 оны хооронд "Германы Нэгдэл" фонд нь тэдгээр муж улсыг санхүүгийн хувьд дэмжиж тэтгэж байв.

Дээр дурдсан суурь хуультай уялдаатайгаар "Эв нэгдлийн холбоо II" хөтөлбөрийг батлан гаргасан бөгөөд энэ нь санхүүг тэнцвэржүүлэх арга хэмжээний нэгэн адил 2005 оноос 2020 он хүртэл хэрэгжих юм. Энэ хугацаанд нийт 306 млрд ДМ-ийн санхүүжилтийг зүүн Германы муж улсуудад хийх бөгөөд энэ нь баруун, зүүн Германы дэд бүтцийг ижил төвшинд хүргэхийн тулд авах арга хэмжээ болно. Үүний 206 млрд ДМ нь санхүүг тэнцвэржүүлэх системийн хүрээнд шууд тэгшитгэн шилжүүлэхэд (жил бүр 14 млрд ДМ), 100 млрд ДМ нь эдийн засгийн дэмжлэг үзүүлэхэд, 6 млрд ДМ нь хуучин өрийг барагдуулахад зарцуулагдах ажээ. "Эв нэгдлийн холбоо II" хөтөлбөрийн жилийн дундаж зардал нь жил бүр 20,6 млрд ДМ-г зүүн германчуудад өгч байсан бөгөөд 1994 онд хэрэгжиж дууссан "Эв нэгдлийн холбоо I" (Solidarpakt I) хөтөлбөрийн зардалтай дүйцэхүйц юм. 1990-2000 оны хооронд Зүүн Германы бүтээн байгуулалтанд нийт 1 биллион буюу 1000 тэрбум ДМ-ийн тусламж дэмжлэгийг үзүүлсэн байна.

**Үйлдвэрийн Үндсэн Хууль:** Үйлдвэрийн Үндсэн хуулийн (Уг хуулинд 1972 онд хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд 7 дугаар сарын 28-нд хүчинтэй болсон) шинэчлэлийг нэлээд маргалдсаны эцэст 6 дугаар сарын 22-нд Бундестаг эрх барьж буй эвслийн нам, АСН-ын саналаар, 7 дугаар сарын 13-нд Бундесрат тус тус баталсан. Уг шинэчилсэн хуулийн дагуу:

- Үйлдвэрийн зөвлөлийн хүлээх үүргийг нэмэгдүүлсний зэрэгцээ үйлдвэрийн хүрээлэн буй орчныг хамгаалах, эмэгтэйчүүдийг дэмжих, бүлгийн ажлын үед баримтлах зарчмуудыг тодорхойлох, мэргэжлийн боловсрол зэрэгт шийдвэр гаргахад түүний оролцох оролцоог нэмэгдүүлсэн;


- 50 хүртэл тооны ажиллагсадтай үйлдвэрт зөвлөл байгуулах ажлыг хөнгөвчилж, сонгуульд оролцох эрх бүхий 100 хүртэл тооны ажиллагсадтай үйлдвэрт сонгуулийн журмыг хялбарчилсны зэрэгцээ Үйлдвэрийн зөвлөлийг сонгоход гардаг ажилчин, албан хаагчдын ялгааг арилган, үйлдвэрийн зарим зөвлөлийн гишүүдийн тоог нэмэгдүүлж, 200-аас дээш (өмнө нь 300) ажиллагсадтай үйлдвэрүүдийн хувьд Үйлдвэрийн зөвлөлийн гишүүдийг үндсэн ажлаас нь гишүүн байх хугацаанд чөлөөлөх боломжтой болгосон;

- Үйлдвэрийн ажиллагсдын хүйсийн харьцаанд тохируулж Үйлдвэрийн зөвлөл дэх эрэгтэй эмэгтэйчүүдийн эзлэх хувийг тогтоож өгөхөөр шийдвэрлэсэн.

Уг хуулинд оруулсан шинэчлэлүүд хүнд суртлыг өөгшүүлсэн, дунд давхаргыг хохироосон, зардал ихтэй, Германы эдийн засгийн байрь сууринд халтай хэмээн Эдийн засгийн холбоод шүүмжилж байв.

**Үнийн хямдралын тухай хуулийг хүчингүй болгов.** – Анх 1933 онд гарсан үнийн хямдралын тухай хуулийг Бундестаг 6 дугаар сарын 29-нд нэмэгдэл олгох журмын (7 дүгээр сарын 25-наас хүчинтэй) хамт хүчингүй болгосон. Үнийн хямдралыг хуулиараа зохицуулдаг (3% хүртэл хүлээн зөвшөөрдөг) Европын Холбооны цорын ганц сүүлчийн улс бол Герман байв.

Герман: 1991 ба 2000 онд нэг ам бүлтэй айл өрхийн эзлэх хувийг насны ангиллаар харуулсан нь



Эх сурвалж: Холбооны Статистикийн Алба, Вийзбаден

## Эрх зүйн бодлого

**Үндсэн Хууль:** 2000 оны 10 дугаар сарын 27-нд Бундестаг 16-ын 2 дугаар зүйлд ("Ямар ч герман хүнийг гадаад улсад шилжүүлж болохгүй") олон улсын шүүхэд шилжүүлэхийг зөвшөөрнө гэсэн нэмэлтийг баталсан.

**Байрны түрээсийн эрх:** Байрны түрээсийн гэрээг цуцлах хугацаа, байрны түрээсийг нэмэгдүүлэх тал дээр түрээслэгчийн хувьд нөхцлийг илтэд сайжруулан шинэчилснийг Бундестаг 3 дугаар сарын 29-нд баталсан. (9 дүгээр сарын 1-нээс хүчинтэй)

**Иргэний хэргийг хянан шийдвэрлэх журмын шинэчлэл:** - Удаан хугацааны туршид маргалдаж, олонтаа өөрчилсний эцэст 5 дугаар сарын 17-нд Бундестаг Иргэний хэргийг хянан шийдвэрлэх шинэ журмыг батлан гаргасан. Анхан шатны шүүхийг бэхжүүлэх явдлыг голлон анхаарсан энэхүү өөрчлөлтийн дүнд шүүхийн байгууллагын үр ашиг, ажиллах чадвар нэмэгдэж, иргэддээ улам ойртох болно гэж Холбооны хууль зүйн сайд Херта Дойблер Гмелин үзэж байв.

**Ижил хүйстэний харьцааг хүлээн зөвшөөрөх тухай** – ХАХ/ХНХ, ЧАН хэдийгээр эсэргүүцэж байсан ч ижил хүйстэнийг гадуурхах явдлыг эцэслэх тухай хуулийг 11 дүгээр сарын 10-нд Бундестаг гаргасан. (2001 оны 8 дугаар сарын 1-нээс хүчинтэй). Үүний хамтаар ижил хүйстэний хүлээн зөвшөөрөгдсөн харьцааг судлах эрхийн институтыг шинээр нээсэн бөгөөд ингэснээр ижил хүйстнүүд жирийн хосуудынхтай төстэй эрх, үүргийг эдлэх боломжтой болох юм. Үүнд нэг овгоор овоглох, тэтгэмжийн мөнгө төлөх үүрэг хүлээх, хүүхэд асрамжлан өсгөх хязгаарлагдмал эрх, өвлөх болон байр түрээслэх, даатгалтай холбогдсон эрхүүд орно. Бавари, Заксен, Тюринген муж улсууд 6 дугаар сарын дундуур уг хуулийн эсрэг гомдол мэдүүлж, өргөдөл гаргасан бөгөөд учир нь уг хууль Үндсэн хуулинд заасан гэр бүлийг дээдлэх үзлийг зөрчиж байна гэж тэд үзжээ. Тэдгээр муж улсууд тухайн хуулийг хэрэгжүүлэх удирдамжийг хуульчилж гаргахаас татгалзсан бөгөөд хуулийг хэрэгжүүлэх удирдамж гаргах нь муж улсуудын хариуцах ажил юм. Дээрхи хуулийг 8 дугаар сарын 1-нээс мөрдөж эхлэхгүй байх талаар түр журам гаргах тухай шийдвэр гаргахыг Бавари, Заксен муж улсууд шаардсан бөгөөд үүнд Үндсэн Хуулийн цэц 7 дугаар сарын 18-нд татгалзан хариу өгсөн.

**Чухал шийдвэрүүд** - Берлиний ханыг даван оргогсдыг буудсан мөн Германы дотор хил тогтоосон гэж БНАГУ-ын Германы Нэгдсэн

Социалист Нам (ГНСН)-ын дарга, Төрийн Зөвлөлийн хамгийн сүүлчийн дарга Эгон Кренц (Egon Krenz), хуучин БНАГУ-ын батлан хамгаалахын сайд Хайнц Кесслер (Heinz Kessler), түүний орлогч Фритц Штрелетц (Fritz Strehletz) болон мөн нэгэн хилийн цэрэг зэрэг хүмүүст ял шийтгэл оноосны эсрэг тэд Штрасбург дэх Европын хүний эрхийн шүүхэд хандсан бөгөөд эцсийн шатны болох уг шүүх 2001 оны 3 дугаар сарын 22-нд уг гомдлыг хүлээж авахаас татгалзсан. Улс төрийн товчоонд хийсэн хэргийнх нь төлөө Берлиний шүүх Кренц-д 1997 онд 6,5 жилийн хорих ял оноосон.

1995 онд хэрэгжиж эхэлсэн асрамжийн даатгалын зарим нэг хэсэг олон хүүхэдтэй айлыг хохироож буй тул Үндсэн хуулинд харшилж байна гэсэн шийдвэрийг Үндсэн хуулийн цэц 4 дүгээр сарын 3-нд гаргаж, хууль тогтоогчдоос уг гажуудлыг засахыг шаардсан.

Салсан нөхөр нь хүүхэддээ төлөх тэтгэмжийн мөнгийг тооцон гаргаж буй шүүхийн өнөөгийн аргачлал нь хүүхэддээ өсөж хүмүүжих таатай боломж олгохын тулд мэргэжлийн ажлаа орхисон эмэгтэйчүүдийг хохироож байна гэж үзээд Үндсэн хуулийн цэц үүнийг 6 дугаар сарын 14-нд хянан засварлав.

### **Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийн талаар явуулж буй бодлого**

**Атомыг хэрэглээнээс гаргах, атомыг тээвэрлэх** – Холбооны Засгийн газар, эрчим хүчээр хангагч аж ахуйн нэгж байгууллагуудтай атомын эрчим хүчийг хэрэглэх явдлыг эцэслэх талаар санал нэгдсэнээс нэг жилийн хойно хоёр тал Германд одоо ашиглалтанд байгаа 19 атомын цахилгаан станцыг ирэх 20 жилийн хугацаанд алхам алхмаар жагсаалтаас гаргах тухай зөвшилцлийн гэрээнд 6 дугаар сарын 11-нд гарын үсэг зуржээ. Ийнхүү тохиролцсон нь 2001 оны эцсээр атомын эрчим хүчийг хэрэглэх явдлыг эцэслэх тухай хуулийг гаргах үндэс суурь болж өгөх юм.

3 дугаар сарын 27/28-нд Франц (La Hague дахь дахин боловсруулах байгууламж) ба Германы (Нийдерзаксены түр хадгалах байр Горлебен /Gorleben/) хооронд атомын хаягдлыг тээвэрлэж, атомыг эсэргүүцэгч германчууд болон цагдаа нарын хооронд хүчтэй мөргөлдөөн гарахад хүргэсэн. Цөмийн хаягдлаас цацраг идэвхт бодис их хэмжээгээр алдагдаж байсны улмаас 1998 онд тусгай саванд хадгалж, тээвэрлэлтийн ажлыг түр зогсоов. Тээвэрлэлт цаашид

Германы атомын цахилгаан станцаас La Hague ба Их Британи дахь Sellafield уруу 4 дүгээр сараас 6 сар хүртэлхи хугацаанд онцын хүндрэлгүйгээр явагджээ.

**Байгаль хамгаалал:** Байгаль орчныг хамгаалах хуулинд хийсэн нэмэлт өөрчлөлтийг Байгаль орчны сайд Триттин Засгийн газарт оруулсныг 6 дугаар сарын 30-нд Засгийн газар баталж, цааш нь Бундестагт хэлэлцүүлэхээр явуулсан. 18 жилийн өмнө баталсан уг хуулийн шинэчилсэн хувилбарт хөдөө аж ахуйг экологийн чиглэлээр хөгжүүлэх зоримог өөрчлөлтийг дэмжихээр тусгажээ. Муж улсууд 3 жилийн дотор газар нутгийнхаа дор хаяж 10%-ийг экологийн цэвэр орчин болгох, үүнийг зохих арга хэмжээ авч баталгаажуулах ажээ.

**Үндэсний ёс суртахууны зөвлөл:** Хүний генийн нууцыг тайлсны үр дагаврыг нийгэм даяараа хэлэлцэж буйтай холбогдуулж 2001 оны 5 дугаар сарын 2-нд Холбооны Засгийн газар Холбооны Канцлерийн санаачилгаар Үндэсний Ёс суртахууны Зөвлөлийг байгуулахаар шийдвэрлэсэн. Уг зөвлөл нь 25 алдартай эрдэмтэн, онолчид, үйлдвэрчний эвлэлийн болон эдийн засгийн төлөөлөгчдөөс бүрдэж буй бөгөөд тэд биотехнологи болон генийн технологийн асуудлыг хэлэлцэж, олон нийтэд мэдээлж, бодлогын зөвлөмжийг гаргах ажээ. 2000 онд Бундестагт байгуулагдсан орчин үеийн эмнэлгийн эрх зүй, ёс суртахууны хороо, Эрүүл мэндийн сайд Андреа Фишер (Andrea Fischer) /Ногоонтны нам/-ийн байгуулсан Ёс суртахууны Зөвлөл байсаар атал ийнхүү Үндэсний ёс суртахууны зөвлөлийг байгуулсан нь үнэндээ илүүц ажил байсан бөгөөд үр хөврөлийг хамгаалах хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах үеэр Холбооны Канцлер өөртэйгээ ойр дөт ажиллах уг зөвлөлөөр дамжуулж Парламентад нөлөө үзүүлэх түүний нэг оролдлого гэж шүүмжлэгчид үзжээ.

### **Улс төрийн дотоод амьдралд болсон бусад үйл явдлууд**

**Холбооны Зэвсэгт хүчин:** Зэвсэгт албыг эмэгтэйчүүдээр хаалгахгүй байхаар Үндсэн Хуулийн 12а дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт заасныг Люксембург дэх Европын Шүүхийн 2000 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн шийдвэрийн дагуу Бундестаг 10 дугаар сарын 27-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтөөр Холбооны Зэвсэгт хүчний бүхий л шатанд эмэгтэйчүүд сайн дураараа алба хааж болох боловч зайлшгүй алба хаах үүрэг хүлээхгүй байхаар заажээ.

Холбооны Зэвсэгт хүчний шинэчлэлийн хүрээнд Холбооны батлан хамгаалахын сайд Рудольф Шарпинг Холбооны Зэвсэгт хүчний 605 цэргийн ангиас 39 том, 20 жижиг ангийг татан буулгах төлөвлөгөөг 2001 оны 1 дүгээр сарын 29-нд танилцуулсан. Холбооны Зэвсэгт хүчний санхүүжилтийн дутууг нөхөх тухай маргаанд Холбооны Канцлер Шредер батлан хамгаалахын болон сангийн сайдын хооронд 5 дугаар сард зуучилж, зөвшилцөлд хүргэж чадсан. 2003-2006 хооронд жил бүр 500 сая ДМ-ийн нэмэлт санхүүжилтийг Холбооны Зэвсэгт хүчинд олгохоор тогтжээ. Мөн үүнээс гадна газар болон цэргийн материал техникийн худалдаанаас олсон ашгийг цаашид өөрсдөө ашиглах эрхийг Холбооны Зэвсэгт хүчинд олгосон.

Долоо хоног тутмын "Die Zeit" сэтгүүлийн эрхлэгч асан Тео Зоммер (Thei Sommer)-ээр ахлуулсан судалгааны комиссыг Шарпинг 1 дүгээр сард байгуулсан бөгөөд уг комисс радарын багажаас ялгарах хортой цацрагнаас цэргүүдээ хамгаалах ажлыг Холбооны Зэвсэгт хүчин 1960-70 онуудад хийгээгүй болохыг тогтоож, 6 дугаар сарын дундуур нийтэлсэн эцсийн тайландаа энэ тухай дурджээ. Уг радарын багажийг ашигласнаар 400-1000 цэрэг хорт хавдраар өвчилж, 70 гаруй нь нас барсан гэжээ. 1999 онд НАТО-гийн агаарын довтолгооны үеэр Америкийн агаарын хүчнийхэн ураны хольц бүхий тэсрэх бодисоор Косовог бөмбөгдсөн бөгөөд тухайн үед Косовод КФОР (KFOR)-ийн бүрэлдэхүүнд дайтаж байсан германы цэргүүд дээрхи бөмбөгдөлтөнд өртөөгүй гэсэн дүгнэлтийг уг комисс хийжээ.

6 дугаар сарын 1-нд Бундестаг дийлэнхи олонхийн саналаар Холбооны Зэвсэгт хүчний Косовод ажиллах эрхийг сунгасан төдийгүй Косово, Өмнөд Сербийн хоорондох 5 км өргөн аюулгүйн зурваст хяналт тогтоох цэргүүдийг нэмж гаргах үүрэг өгчээ.

**Цагаачлалын бодлогод гарсан өөрчлөлт:** Холбооны Дотоод Явдлын яамны сайд Отто Шили цагаачлалын хуулийн төслийг 2001 оны 8 дугаар сарын 3-нд танилцуулсан ба уг хууль нь тухайн үеийн Гадаадын иргэдийн хуулийн оронд үйлчилж, цагаачлал Германы хөдөлмөрийн зах зээлд чиглэж буйг зохицуулах, орогнол үзүүлэхэд шинэ зохицуулалт хийх, гадаадын иргэдийг интеграцчилах хөтөлбөрийг шинэчлэх ажээ. Уг хуулийн төсөл нь цагаачлалын комиссоос боловсруулан гаргаж, 7 дугаар сарын 4-нд олон нийтэд танилцуулж байсан гол саналуудыг өөртөө тусгасан бөгөөд дээрхи комиссыг Шили 2000 оны 7 дугаар сард байгуулж, Бундестагийн ерөнхийлөгч асан Рита Сюсмит (Rita Süßmuth) /XAX/-ээр удирдуулсан

ажээ. ХАХ/ХНХ-ны зүгээс Сюсмитийн концепцийг хүлээн авах боломжгүй гэж үзсэнийг концепцийн мөн зарим нэг санааны хувьд Шили харгалзан үзсэн талтай.

Цагаачлалын хуулийн төслийн үндсэн санаанууд:

- Германд оршин суух зөвшөөрөл хугацаатай, хугацаагүй байхаас хамаарч оршин суух эрх ялгавартай байх бөгөөд үүнд ямар зорилгоор оршин суух вэ гэдэг нь шийдвэрлэх чухал нөлөөтэй гэжээ. (хүмүүнлэгийн шалтгаан эсвэл боловсрол эзэмших, ажиллах, гэр бүлийнхээ хойноос нүүж ирэх эсэхээс хамаарна).
- Германд ирж буй ажиллах хүчин тухайн орны хөдөлмөрийн зах зээл үрүү цаашид ч мөн чиглэх бөгөөд тэдгээрээс өндөр мэдлэг, чадвартай хүмүүст удаан хугацаагаар оршин суух эрхийг даруй олгоно. Холбооны миграц, дүрвэгсдийн асуудал эрхэлсэн алба (Энэ нь Гадаадын дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх холбооны албаны оронд бий болсон)-наас тусгай шалгуураар сонгож авсан зохих цагаачдад “Шардлагатай нөхцөлд” хугацаагүй оршин суух эрхийг олгоно. Уг шалгуурт амьжиргааны баталгаа, мэргэжлийн боловсрол, нас, мэргэшил, хэлний мэдлэг, Герман болон төрөлхи нутагтайгаа харилцах харилцаа зэрэг орно. Гадаадын оюутнууд сургуулиа төгсөөд заавал нутагтаа буцах албагүй мөн үлдээд ажил хийж болно гэжээ.
- Хүмүүнлэгийн шалтгааны улмаас хүлээн авч нутагтаа байрлуулж буй хүмүүс харих боломжгүй байвал хугацаатайгаар оршин суух зөвшөөрөл өгөх бөгөөд бусад хүмүүсийн хувьд буцаж харих үүргээ “чанд биелүүлэх” ёстой. Нутагтаа толгой хорогдуулж, орогнуулах статус өгөх явдлыг болиулсан. Дүрвэгсдийн тухай Женевын конвенцэд заасан дүрвэгсэд болон Үндсэн хуулийн 16а дугаар зүйлийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн улс төрийн орогнол хүсэгчид хугацаатайгаар оршин суух зөвшөөрөл авах эрхтэй. Гурван жилийн дараа удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийг олгохоос өмнө тухайн дүрвэгч, орогнол хүсэгчийн эх нутагт байдал өөрчлөгдсөн эсэхийг шалгаж үзнэ.
- Удаан хугацаагаар оршин суух эрх бүхий цагаачид интеграцчилах хөтөлбөрт оролцох эрхтэй бөгөөд герман хэлний мэдлэггүй ба зургаагаас доош жилийн хугацаагаар оршин сууж буй хүмүүс уг хөтөлбөрт зайлшгүй хамрагдах үүрэгтэй.

**Нацизмын үед албадлагаар ажиллагсдад нөхөн олговор олгох фонд:** Олон сарын хугацаагаар алгуурласны эцэст Бундестаг 2001 оны 5 дугаар сарын 30-ны өдөр шийдвэр гаргаж, 2000 оны 7 дугаар сард байгуулагдсан “Дурсамж, хариуцлага, ирээдүй” холбооны сангаас нацизмын үед албадлагаар ажиллаж байсан хүмүүст нөхөн олговор олгох асуудлыг нэг мөр болгосон. Германы аж үйлдвэрүүд өөрийн хувь болох 5 млрд ДМ-ийг нөхөн олговрын санд баттай шилжүүлэх болсноор Германы банкнуудын эсрэг гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гаргах нөхцөл биелэгдлээ гэж Нью-Йоркын шүүх 5 дугаар сарын 10-нд үзсэн. Ингэснээр хууль зүйн үүднээс авч үзэхэд зайлшгүй шаардлагатай байсан эрх зүйн орчинг Германы аж үйлдвэрүүдэд бий болгож чадсан юм. 1,4 млрд ДМ дутаж байсны улмаас эргэлзээ төрж байсан хэдий ч Холбооны санг үүсгэн байгуулсан 17 гишүүн өгөх хандиваа нэмэгдүүлж, дампуурахгүй байх баталгааг гаргах үүрэг хүлээснээ 3 дугаар сарын 13-нд мэдэгдсэнээр тэр эргэлзээг үгүй болгосон. Охин компанийн хамтаар нийт 6485 аж ахуйн нэгж 8 дугаар сарын 10-ныг хүртэл мөнгө хандивлаж хувь нэмрээ оруулснаар Холбооны сан улсаас гаргасан 5 млрд ДМ-ын хамтаар нийт 10 млрд ДМ-тай болсон. Тухайн улсад байрлаж нөхөн олговрыг тарааж өгөх салбаруудад 6 дугаар сарын дундуураас эхэлж Холбооны сан мөнгөө гуйвуулж эхэлсэн. Хуваарилалтын дагуу АНУ дахь хохирогч еврейчүүдэд тусгай байгууллагаар (Jewish Claims Conference) дамжуулж 1,8 млрд ДМ; польшуудад 1,8 млрд ДМ; украинчуудад 1,7 млрд ДМ; оросуудад 0,8 млрд ДМ; белорусь нарт 0,7 млрд ДМ; чехүүдэд 0,4 млрд ДМ; бусад улсуудад 0,8 млрд ДМ-г; эд материалын хохиролд 1,0 млрд ДМ; ирээдүйн фондод 0,7 млрд ДМ-н нөхөн олговрыг тус тус олгохоор болжээ. Холбооны сангийн Удирдах Зөвлөл 6 дугаар сарын дунд үед тооцоо гаргаж, анх төлөвлөснөөс 300.000-аар илүү букуу 1,5 сая хохирол нөхөн төлүүлэх тухай өргөдөл авсан болохыг тогтоосон тул нэг хүнд ногдох нөхөн төлбөрийн хэмжээг бууруулахаас аргагүй болсон. (Хорих лагерьт “боолын ажилчин” болж байсан хохирогсдод 5000-15.000 ДМ өгөхөөр төлөвлөж байжээ)

**Улсын аюулгүй байдлын албаны баримт бичгийн талаархи маргаан** – Хуучин БНАГУ-ын Улсын аюулгүй байдлын албаны бичиг баримтыг Марианне Биртлер (Marianne Birthler) хариуцан ажиллаж байх үед Берлиний Захиргааны хэргийн шүүх Холбооны Канцлер асан Хельмут Колийн хүсэлтээр 7 дугаар сарын 4-нд 2500 орчим

хуудас баримт бичгийн тэмдэглэлийг нийтэд задлалгүйгээр цаашид чандлан хадгалахыг Марианне Биртлер-т үүрэг болгосон. Учир нь телефон утасны ярианы нууц бичлэг сэлтийг агуулсан дээрхи материалуудыг нийтлэх нь тухайн үеийн түүхийг бүтээгчдийн нэг болох Колийн сонирхолд нийцэхгүй байсан юм Биртлер 2000 оны 10 дугаар сарын 11-нд Йоахим Гаук (Joachim Gauck)-ийн оронд хуучин БНАГУ-ын Улсын аюулгүй байдлын албаны бичиг баримтыг хариуцан ажиллах болсон бөгөөд тэрээр нэг талаас түүхийг судлах зорилгоор нөгөө талаас 1991 онд хүчин төгөлдөр болсон Улсын аюулгүй байдлын албаны баримт бичгийн тухай хуулийн заавар журмын дагуу Улсын аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг тайлбарлахын тулд Кольтой (нэн шинэ түүхийг бүтээгчдийн нэг болохын хувьд) холбогдолтой баримт бичгүүдийг нийтлэн гаргахыг өөрийн үүрэг гэж үзэж байлаа. Энэ тал дээр Холбооны Дотоод явдлын сайд Отто Шили мөн Кольтой санал нэгтэй байж, тэдгээр баримт бичгүүдийг хэвлүүлэхгүй байх тушаал өгч байсан төдийгүй бусад нэр алдар бүхий хүмүүстэй холбогдох баримт бичгүүдийг нийтэд задлахгүй байх шийдвэр гаргахыг зохих хүмүүсээс шаардаж байв.

**Хэт барууны үзэл** - Холбооны Дотоод Явдлын Яамны сайд Шили Үндсэн хуулийн халдашгүй дархан байдлыг хэрхэн хамгаалсан тухай 2001 оны 3 дугаар сарын 29-нд ирүүлсэн ажлын тайланд дурдсанаар 2000 онд хэт барууны үзэл дээр суурилсан гэмт хэрэг 1999 онтой харьцуулахад 59%-иар өсөж 15.951 хэрэг (үүний дотор хүн амины хэрэг гурав гарсан)-т хүрээд байгаагаас хүч хэрэглэсэн гэмт хэрэг (гурван хэрэг тутмын 2 нь гадаад иргэдийн эсрэг чиглэсэн гэмт хэрэг байв) 34%-иар өсөж, 998 тохиолдолд хүрсэн байна. Гэмт хэргийн 1378 (+69%) тохиолдолд еврэйчүүдийн эсрэг байв. Хэт баруунтны үйлдсэн хэргийг ард иргэд цагдаад мэдэгдэх нь нэмэгдсэн явдал гэмт хэргийн тоон үзүүлэлт өсөхөд голчлон нөлөөлсөн хэмээн Шили дурджээ. Хэт барууны үзэлтэй 9700 орчим залуус Заксен, Тюринген, Зүүн Берлинд төвлөрч байна гэсэн тооцоог Үндсэн хуулийг хамгаалах холбооны алба хийсэн байна. 5 дугаар сарын эхээр холбоо болон муж улсуудын дотоод хэргийн сайд нар хэлэлцээд "улс төрийн шинжтэй гэмт хэрэг" гэсэн төрөл зүйлийг цагдаагийн статистикт оруулах нь зүйтэй гэдэг дээр санал нэгдсэн.

Хэт барууны үйл ажиллагааны эсрэг олон нийтийг хамарсан эсэргүүцэл хөдөлгөөн олонтаа өрнөсөн. 2000 оны 11 дүгээр сарын 9-нд буюу 1938 онд еврей нарын эсрэг бусармаг аллага явагдсан тэр

нэгэн хар өдрийг дурсан Берлин хотноо болсон томоохон жагсаалд 200.000 гаруй хүн оролцжээ.

**Хориглосон тухай шийдвэр гаргасан нь** – Олон улсын хэт барууны үзэлтэй байгууллагын сүлжээн дэх Германы секц болох “Blood & Honour” (хөгжмийн салбарт үйл ажиллагаа явуулдаг) бүлгийн үйл ажиллагааг 2000 оны 9 дугаар сарын 14-нд Холбооны Дотоод явдлын яамны сайд хориглосон. Нордрайн-Вестфален, Заксены Дотоод явдлын яамны сайд нар 2001 оны 1 дүгээр сарын 24-нд “Hell’s Angels Germany Charter Düsseldorf”, 2001 оны 4 дүгээр сарын 5-нд “Skinheads Sdchsische Dÿsseldorf” зэрэг рок хамтлагуудыг тус тус хориглосон.

Хэт барууны үзэл, еврэй нарын эсрэг үзэл, гадаадынхны эсрэг үзэлтэй тэмцэх (ялангуяа Зүүн Германд) санал санаачилгыг дэмжихэд зориулж нийт 65 сая ДМ-ийн өртөг бүхий үйл ажиллагааны хөтөлбөрийг Холбооны гэр бүлийн сайд Кристине Бергманн (Christine Bergmann) 2 дугаар сарын 27-нд танилцуулсан. 4 дүгээр сарын 17-нд Үндсэн хуулийг хамгаалах холбооны алба хэт барууны үзэлтнүүдэд зориулан тэднийг хэт барууны үзэлтний эгнээнээс гаргах хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн.

Германы Үндэсний Ардчилсан намын үйл ажиллагааг хориглохыг хүссэн өргөдлийг Карлзруэ дэх Холбооны Үндсэн хуулийн цэцэд Холбооны Засгийн газар 2001 оны 1 дүгээр сарын 31-нд гардуулсан. 6000 гишүүнтэй Германы Үндэсний Ардчилсан нам нь 14000 гишүүнтэй Бүгд найрамдахчууд, Германы ард түмний холбооны дараа орох Германы гуравдагч том хэт барууны үзэлтэй нам юм. Бундесрат, Бундестаг нь 2000 оны 10 дугаар сарын 26, 12 дугаар сарын 8-ний өдрүүдэд гаргасан тус тусынхаа шийдвэрийг үндэслэн дээрхи намын үйл ажиллагааг хориглох тухай өргөдлийг 3 дугаар сарын 29-нд гаргасан байна.

### Улс төрийн намууд

**Холбоо 90/Ногоонтны нам:** Ренате Кюнаст 1 дүгээр сард Холбооны засгийн газрын гишүүн болсны дараа Штуттгартад 2001 оны 3 дугаар сарын 10-нд намын хурал хуралдаж, гишүүдийн 91,5%-ийн саналаар Бундестагийн гишүүн Клаудиа Рот (Claudia Roth)-ийг намын даргаар сонгосноор тэрээр Фритц Куун (Fritz Kuhn)-ы хамт уг намыг даргалах болжээ.

**Христосын Ардчилсан Холбоо (ХАХ)**: ХАХ-ны намын бага хурлаар Нордрайн-Вестфален муж улсын парламентын дэд дарга асан Лауренц Мейер (Laurenz Meyer)-ийг 2000 оны 11 дүгээр сарын 20-нд гишүүдийн 99%-ийн саналаар намын ерөнхий нарийн бичгийн даргаар сонгосон. 10 дугаар сарын 23-нд огцорсон Рупрехт Поленц (Ruprecht Polenz)-ийн халааг Лауренц Мейер авсан ажээ.

Намын хандивын будлиантай хэрэг мандах үед 3,4 сая ДМ-ийн улсын татаасыг багасгах шийдвэрийг Бундестагийн ерөнхийлөгч Вольфганг Тийрзе (Wolfgang Thierse) 12 дугаар сарын 1-нд гаргасан. Энэ нь зэвсгийн лоббичин Карлхайнц Шрайбер (Karlheinz Schreiber)-аас 1991 онд тухайн үеийн сангийн нярав асан Вальтер Лайслер Кийп (Walter Leisler Kiep)-д тушаасан 1 сая ДМ-ийн хандивыг бүртгэхгүй авсны төлөө шийтгэсэн хэрэг болжээ. 2001 оны 3 дугаар сард Кийп ХАХ-ны дансанд 1 сая ДМ гуйвуулсан бөгөөд хаанаас ирсэн нь тодорхой бус энэ мөнгийг ХАХ эзэмших эрхтэй бөгөөд энэ мөнгө Шрайберээс ирээгүй гэж тэрээр мэдэгдсэн. 2001 оны 1 дүгээр сарын 31-нд Берлиний Захиргааны хэргийн шүүх ХАХ-тай холбогдох 41 сая ДМ-ийн торгуулийг хүчингүй болгосон. Хессен дэх ХАХ-ны салбараас хууль бус замаар шилжин ирсэн 18 сая ДМ-ийг ХАХ өөрийн санхүүгийн тайландаа тусгаагүй байсан учир Бундестагийн ерөнхийлөгч 2000 оны 2 дугаар сард шийтгэл оноосон. ХАХ-д үнэнч байгаагүйн улмаас Холбооны Канцлер асан Колийн эсрэг хавтаст хэрэг нээснийг 300.000 ДМ-ийн торгууль төлүүлж хаалгах тухай улсын прокурорын газрын хүсэлтийг Бонн дахь мужийн шүүх 3 дугаар сарын 2-нд хүлээн зөвшөөрсөн.

**Германы Чөлөөт Ардчилсан Нам (ЧАН)** – 5 дугаар сарын 5-нд хуралдсан Намын хурлаар тухайн үед гүйцэтгэх захирлын алба хашиж байсан Гуидо Вестервелле (Guido Westerwelle)-г 89,4%-ийн саналаар Вольфганг Герхардт (Wolfgang Gerhardt)-ийн залгамжлагч болгон намын даргаар сонгосон. Заксен-Анхальт муж дахь намын үүрийн дарга байсан хатагтай Корнелиа Пийпер (Cornelia Pieper) гүйцэтгэх захирлаар сонгогджээ. Харин Герхардт Бундестагийн фракцийн дарга хэвээр үлдсэн.

**Ардчилсан Социализмын Нам (АСН)** – Намын дарга асан Лотар Биски (Lothar Bisky) намын удирдлагад дахин нэр дэвшихээс татгалзсаны дараа 2000 оны 10 дугаар сарын 14-нд Коттбус гэдэг

газарт хуралдсан Намын хурлаар тухайн үед намын орлогч дарга бөгөөд Тюрингений фракцийн дарга байсан Габрийле Циммер (Gabriele Zimmer)-ийг төлөөлөгчдийн 93%-иар саналаар намын тэргүүнээр сонгосон. Хурлын төлөөлөгчид гаргасан нэгэн шийдвэртээ ГСДН-тай нягт хамтран ажиллахыг санал болгосон ажээ.

1946 онд ГСДН, Германы Коммунист Нам хоорондоо нэгдэж Германы Социалист Нэгдсэн Намыг (ГСНН) байгуулсны 55 жилийн ойг тохиолдуулан 2001 оны 4 дүгээр сарын 18-нд хатагтай Циммер ГСНН-ын халааг авсан АСН-ын өмнөөс ГСДН-аас уучлалт гуйсан бөгөөд дарамт шахалт, хууран мэхлэлтийн дор ГСДН-ыг хүчээр нэгтгэсний дээр ГСНН-хан социальдемократуудыг мөрдөж мөшгиж байсанд мөн уучлал хүсчээ.

АСН-ын үндсэн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан төслийг хатагтай Циммер 4 дүгээр сарын 27-нд танилцуулсан бөгөөд уг төсөлд парламентын -олон ургальч тогтолцооны үнэт зүйлийн хүрээнд АСН-ыг ардчилсан социалист хүчин болгож шинэчлэхээр тусгажээ.

### Байгууллагууд

#### Үйлчилгээний салбарын үйлдвэрчний эвлэл ver.di (Vereinte Dienstleistungsgewerkschaft)-ийг үндэслэн байгуулсан нь:

2001 оны 3 дугаар сарын 19-нд Берлинд үйлчилгээний салбар дахь үйлдвэрчний эвлэлүүдийг нэгтгэсэн ver.di байгуулагдсан. Германд төдийгүй дэлхийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбоодоос хамгийн том нь болох ver.di 1000-аад төрлийн мэргэжлийн 2,9 сая гишүүдтэй, 13 салбарыг нэгтгэсэн бөгөөд энэ нь Германы үйлдвэрчний эвлэл холбоодод хамрагдаж ордоггүй Германы албан хаагчдын үйлдвэрчний эвлэл болон үйлчилгээний салбарт үйл ажиллагаагаа явуулдаг дөрвөн үйлдвэрчний эвлэлийн нэгдлээс үүссэн юм. Тэд тус тусын хуралдааныг хийж, хоорондоо нэгдэх нь зүйтэй гэсэн ерөнхий чигийг 1999 оны 11 дүгээр сарын 19-нд гаргасан бөгөөд хоорондоо нэгдэн нийлэх нь ver.di-г байгуулах урьдчилсан нөхцөл мөн гэсэн шийдвэрийг тэд 2001 оны 3 дугаар сарын 16, 18-ны өдрүүдэд гаргажээ. (Германы шуудангийн салбарын үйлдвэрчний эвлэл - 91,4%; Германы албан хаагчдын үйлдвэрчний эвлэл - 89,3%; Төрийн байгууллага, тээвэр, зам харилцааны салбарын үйлдвэрчний эвлэл - 87,1%; Худалдаа, банк, даатгалын салбарын үйлдвэрчний эвлэл - 84,4%; IG мэдээллийн хэрэгсэл -80%; Зөвшөөрөн батлахад шаардагдах хувь -

80%; IG мэдээллийн хэрэгсэл - 75%). ver.di-ийг үүсгэн байгуулах хурал дээр тухайн үед төрийн байгууллага, тээвэр, зам харилцааны үйлдвэрчний эвлэлийн дарга асан Франц Бсирске (Frank Bsirske) / Холбоо 90/Ногоонтны нам/-г 95,9%-ийн саналаар шинэхэн байгуулагдсан уг үйлдвэрчний эвлэлийн анхны даргаар сонгогджээ.

### Гадаад бодлого

**АНУ:** Бушийн засаг захиргаа тогтсоноос хойш хэд хэдэн зүйл дээр санал зерелдсэн бөгөөд тухайлбал үүнд пуужингийн довтолгооноос хамгаалах үндэсний системийг байгуулах маргаантай теслиг АНУ-ын ерөнхийлөгч цааш үргэлжлүүлэх бодолтой байсан явдал зэрэг орно. 2001 оны 3 дугаар сарын 29-нд Холбооны Канцлер Шредер Вашингтонд албан ёсны айлчлал хийх үед Шредер ба ерөнхийлөгч Бушийн хооронд нэгэн илэрхий маргаан үүссэн бөгөөд энэ нь уур амьсгалын дулааралтай тэмцэх Киотогийн үйл ажиллагаанаас АНУ гарахаар шийдсэнээс үүдэлтэй юм.

АНУ-ын эсрэг мэдүүлсэн ХБНГУ-ын гомдлыг Гаагын олон улсын шүүх 6 дугаар сарын 27-нд хүлээн дэмжсэн бөгөөд Германы харъяат ах дүү Карл Ла Гранд, Вальтер Ла Гранд нар (Karl und Walter LaGrand)-ыг 1999 онд цаазаар авсан эл хэрэгт консулын шугамаар эрхийн туслалцаа үзүүлэхээс татгалзаж, олон улсын түгээмэл эрх зүйд зайлшгүй дагаж мөрдөх ёстой Консулын эрхийн тухай Вений конвенцийг зөрчсөн болохыг тогтоожээ.

**БНХАУ:** БНХАУ-тай бүхий л салбарт хамтын ажиллагаагаа идэвхжүүлж буй нь сайд нарын төвшинд төрөл бүрийн хэлхээ холбоо тогтоож буйгаас харагдаж байна. Шанхайн нисэх онгоцны буудлыг хотын төвтэй холбосон соронзон түлхэлттэй анхны хурдан галт тэрэгний замыг (30 км, 2 млрд орчим ДМ-ийн өртөгтэй) Германы технологиор барих гэрээг байгуулсны дараа Барилга, зам тээврийн сайд Курт Бодевиг 5 дугаар сарын эцсээр Бээжинд ирээд Шанхай, Хятадын нийслэл хоёрыг холбосон хурдан галт тэрэгний зам (1300 км) барих боломжийг судалж, энэ салбарт цаашид хамтран ажиллах замыг зассан юм.

**Австри:** Барууны популист чиглэлийн Австрийн Эрх чөлөөний нам (FDЦ) засгийн эрхэнд гарсны (2000 оны 2 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд) улмаас Европын Холбооны гишүүн орнууд Австрийн эсрэг тавьсан найман сарын хоригийг цуцалсны дараа ч Герман

Австрийн харилцаа тааруу хэвээр үлдсэн, учир нь өөрийн хөрш орон болох Австрийн эсрэг хатуу байр суурь баримталсан гол орнуудын нэгэнд Герман орж байв. Холбооны Канцлер Шрёдер 2001 оны 5 дугаар сарын 25/26-нд Венад ээлжит айлчлалаа хийж, тухайн улсын сөрөг хүчнийг албан ёсны төлөөлөгчдөөс нь илүүтэйгээр сайшаан хандсан бөгөөд үүнийг ард иргэдийн зүгээс зарим талаар ихэд эмзэглэн хүлээж авсан.

**Ойрхи Дорнод/Израиль** – Холбооны Засгийн газар улам бүр хурцдаж буй Израиль, Палестины асуудлаар нэг талыг баримталсан байр суурийг албан ёсоор илэрхийлэхээс ямагт зайлсхийсээр ирсэн билээ. 2000 оны 10 дугаар сарын сүүлээр Холбооны Канцлер Ойрхи Дорнодын зургаан орноор айлчлахдаа зуучлагчийн үүргийг гүйцэтгэхээс татгалзсан бөгөөд зуучийн үүргийг мөн л урьдын адил зөвхөн АНУ гүйцэтгэх нь тохиромжтой гэж үзсэн ба энх тайвныг тогтоох явцыг шинэчлэх арга замыг хайхад “дэмжлэг үзүүлэхүйц” үүрэг хүлээхийг тэрээр сөргөлдөгч талуудад санал болгож байлаа. Холбооны Гадаад хэргийн сайдын 6 дугаар сарын 1-4 хооронд хийсэн ээлжит айлчлал нь Тель-Авивт ноцтой аллага гарах үетэй давхацсан боловч Израиль, Палестины удирдлагыг шууд гал зогсоох шийдвэрт Фишер хүргэж чадсан байна.

**Африкт явуулж буй бодлого** - 2000 оны 3, 11 дүгээр саруудад Холбооны Гадаад Хэргийн сайд Фишер хэд хэдэн африкийн орнуудад айлчлаад ирсний дараа 2001 оны 4 дүгээр сарын 11-нд Холбооны Засгийн газар Африкт явуулах бодлогын үзэл баримтлалыг (Африкийн Сахараас урагш баримтлах гадаад бодлогын стратеги) гаргасан. Улс төр, хөгжлийн хамтын ажиллагааг чиглүүлэх үндсэн талбар бол “ядууралтай тэмцэх, хүнс тэжээлийн хүрэлцээг баталгаажуулах, хангалуун амьдралыг цогцлуулах урьдач нөхцөл болсон улс төр, нийгмийн тогтвортой байдлыг бий болгох явдал мөн” гэж тодорхойлсон.

### **Муж улсуудад болсон гол үйл явдлууд**

**Баден-Вюрттемберг:** 2000 оны 3 дугаар сарын 25-нд болсон парламентын сонгуульд ХАХ 44,8%-ийн санал авч, 1996 оны сонгуультай харьцуулахад 3,5%-иар өссөн дүнгээр муж улсдаа хамгийн хүчтэй улс төрийн нам болсон байна. ГСДН Уте Фойгт (Ute Voigt)-ыг гол кандидатаар нэр дэвшүүлж, 33,3%-ийн (+8,2%) санал

инснаар мөн л өссөн үзүүлэлттэй гарчээ. Том намууд ийнхүү ахиу саналыг авсан нь жижиг намуудын байдлыг хүндрүүлсэн: ЧАН 8,1%-ийн санал авч, -1,5%-иар буурсан үзүүлэлттэй байхад Холбоо 90/Ногоонтны нам 7,7%-ийн саналаар -4,4%-тай байв. Гэтэл хэт барууны Бүгд найрамдахчууд 4,4%-ийн санал (өмнөх сонгуулиар 9,1%-ийн санал авч байсан) авч Парламентэд суудал авч чадаагүй билээ. Ерөнхий сайд Эрвин Тойфель (Erwin Teufel) эвслийн намаа шинэчлэн ЧАН-ыг сонгож авсан бөгөөд ирэх таван жилд дөрөвдэх удаагаа сонгогдон ажиллах эрхийг түүнд мужийн парламент 6 дугаар сарын 13-нд баталгаажуулж өгчээ.

**Берлин:** ХАХ-ны фракцын дарга бөгөөд банкны менежер Клаус Ландовский (Klaus Landowsky)-той холбогдох хандивын мөнгөний хэрэг дэгдсэн, нөгөөтэйгүүр Берлиний банкны нийгэмлэг төлбөрийн чадварын хямралд орсон зэрэг явдал нь Эберхард Дийпген (Eberhard Diepgen)-ийг /ХАХ/ хотын амбан захирагчийн албанаас унагаж, Клаус Вуверайт (Klaus Wowereit)-ын /ГСДН/ захиргаан дор түр засгийн газрыг байгуулахад хүргэжээ. 1990-ээд оны үед ХАХ-ны фракцын данс тооцоо бүрэн гүйцэд хөтлөгдөөгүй, дүрэм журмын дагуу бүртгэлгүй хандивын мөнгийг (40.000 ДМ) хүлээн авсан болохыг илрүүлсэн бөгөөд үүний дараа 2001 оны 3 дугаар сарын 7-нд Берлин-Хип (Berlin-Hip)-ын Удирдах Зөвлөлийн мэдээлэгчийн албанаас Ландовскийг Берлин-Хипын 1995 оны зээлийн ажиллагаатай холбогдуулан огцруулсан. Берлин-Хип нь 56,6 хүртэлхи хувь нь Берлинд хамаарагдах Берлиний Банкны Нийгэмлэгийн охин компани юм. 1990-ээд оны үед үл хөдлөх хөрөнгийн наймааг аз туршин хийснээс 3,9 млрд ДМ-ийн хөрөнгийн алдагдалд орсон Берлиний Банкны Нийгэмлэгийг төлбөрийн чадваргүй байдалд оруулахгүйн тулд 5 дугаар сарын 22-нд Сенат албан ёсны баталгаа гарган өгөхөөс өөр аргагүйд хүрсэн. Ингэснээр муж улсын шинээр тавьсан өр өссөн бөгөөд үүнд мөн 2001 онд хувьчлалаас олох ашгийг 3,6 млрд ДМ гэж тооцож байсныг 9,5 млрд ДМ гэж өсгөсөн нь бас ихэд нөлөөлсөн. Гамшгийн үед улс төрийн үүрэг хариуцлага ямар байх талаар маргалдаж улмаар 6 дугаар сарын 7-нд ГСДН эвслээ тараасан бөгөөд 6 дугаар сарын 15-нд (169 гишүүнтэй) ГСДН, Ногоонтны нам, АСН-ын 87 гишүүний саналаар Дийпген-д итгэл үл үзүүлэх тухай саналыг Парламент хүлээн зөвшөөрсөн. Түүнийг огцорсноос нэг хоногийн хойно 89 гишүүний саналаар тухайн үед ГСДН-ын фракцын дарга байсан Клаус Вуверайтыг хотын амбан захирагчаар сонгосон.

Ногоонтны нам, ЧАН-аар хүлээн зөвшөөрүүлж, ГСДН-ын засгийн газар бүрдүүлэхийг Клаус Вуверайт 10 дугаар сарын 21-нд товлосон сонгууль хүртэлхи хугацаанд зорьж байсан юм. Хотын амбан захирагчийн албан тушаалд ХАХ фракцын дарга Франк Штеффел (Frank Steffel)-ийг, ГСДН Вуверайтыг, АСН Грегор Гизи (Gregor Gysi)-ийг тус тус нэр дэвшүүлсэн.

**Райнланд-Пфальц:** 2001 оны 3 дугаар сарын 25-нд болсон мужийн парламентын сонгуульд ГСДН 44,7%-ийн санал авч (1996 онд 39,8%-ийн саналыг авч байжээ), тэргүүлэх нам болохоо дахин нотолсон. ХАХ 35,3%-ийн (-3,4%) санал авч, муж улсын түүхнээ хамгийн бага саналыг авчээ. ЧАН 7,8% (-1,1%), Холбоо 90/Ногоонтны нам 5,2% (-1,7%) санал авсан нь буурсан үзүүлэлттэй байв. Мужийн парламент 5 дугаар сарын 18-нд ерөнхий сайд Курт Бек (Kurt Beck)-ийг /ГСДН/ Засгийн газрын тэргүүнээр (Засгийн газар нь ЧАН-тай эвсэл байгуулсан) дахин таван жилийн хугацаагаар сонгосон.

**Заарланд:** Уг мужийн Ерөнхий сайд асан Райнхард Климмт (Reinhard Klimmt) /ГСДН/ Холбооны сайдын албан тушаалаасаа огцорсны дараа Заарландын дотоод хэргийн сайд Клаус Майзер (Klaus Meiser) /ХАХ/ 1. ФЦ Заарбрюкен хөл бөмбөгийн холбоог тойрсон санхүүгийн будлиант хэргийн улмаас 2000 оны 11 дүгээр сарын 16-нд албан тушаалаасаа буусан бөгөөд тэрээр уг холбооны дэд ерөнхийлөгч нь байжээ. 12 дугаар сарын 20-нд хуралдсан Намын онц хурал фракцын дарга байсан Хейко Маас (Heiko Maas)-ыг /ГСДН/ Климмтын залгамжлагчаар буюу мужийн намын даргаар сонгосон байна.

**Заксен:** Мужийн ХАХ-ны боловсон хүчний асуудлаар маргаан дэгдэсний дараа намын дарга бөгөөд ерөнхий сайд Курт Бийденкопф (Kurt Biedenkopf) сангийн сайд Георг Милбрадт (Georg Milbradt)-ыг ажлаас нь халсан бөгөөд Георг Милбрадт нь 71-н настай ерөнхий сайдын халааг авах хамгийн их найдвартай нэр дэвшигчийн нэгэнд тооцогдож байжээ. Тэрээр хэд хэдэн тохиолдол дээр хувийн сонирхлоо албан ажилтайгаа холисон гэж зэмлүүлсний дараа сөрөг хүчнийхэн 2001 оны 5 дугаар сарын 16-нд Бийденкопфыг эгүүлэн татах тухай өргөдөл гаргасан. Бийденкопф үүнийг давж гарч чадсан боловч түүний нэр хүнд ихэд унасан. Түрээсийн асуудалтай холбогдуулан тэрээр 6 дугаар сард 123.000 ДМ-ыг Заксены чөлөөт муж улсад төлж, хохирлыг барагдуулсан.